

П. СОРОКИН

(орч) Т.Бүрэнжаргал

*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн ухааны доктор (PhD)*

СОЦИОЛОГИЙН СИСТЕМ

Abstract: *Pitirim Sorokin (1889-1968) - the famous social scientist of the 20th century. In 1922, he published "System of Sociology" which was presented to the public debate as a doctoral dissertation. In the "System of Sociology," Sorokin offers the basic principles on the basis of which he proposed the creation of sociology. He developed a framework of sociology, its main direction and objectives. In the "System sociology" Sorokin explains in detail the scientific principles that based his work.*

Key words: *Pitirim Sorokin, social scientist, system of Sociology, attitude to science*

Удиртгал

Бүлэг I. Социологийн судлах зүйл ба түүний бусад шинжлэх ухаанд хандах хандлага

§1. Социологийн судлах зүйл

Социологийн үндсэн ойлголтууд, түүний бүтэц, шинж төлөвийг социологичид болон “олон нийт”¹ өнөөг болтол янз бүрээр ойлгож ирсэн. Ийм учраас социологийн онолч болгоны нэн тэргүүний зорилт бол судлах зүйл болон салбар ухааны хил хязгаарыг тодорхойлж өгөх явдал юм. Үүнийг шийдвэрлэж үл чадваас социологич нийгмийн үзэгдлүүдийн нарийн төвөгтэй ертөнцөд төөрч түүний үзэл бодлыг ойлгомжгүй, тодорхой бус хэмээх зүй ёсны зэмлэл хүлээнэ.

Энэхүү зорилтыг шийдвэрлэхээс би өөрийнхөө социологийн курсээ өгүүлж эхлэх болно.

Социологи нь бие даасан шинжлэх ухаан болохыг дараах зүйлийг тодруулснаар харж болно. Үүнд: нэгдүгээрт, түүний судалгааны хүрээг гаргах; хоёрдугаарт, судлах асуудлын чухлыг тодорхойлж, бусад шинжлэх ухаанууд судалдаггүй болохыг тогтоох; гуравдугаарт, социологи нь бусад шинжлэх ухаан ялангуяа нийгмийн /социаль/ салбар ухаанд хандах хандлагыг тодорхойлох явдал билээ.

Ийнхүү социологийг тодорхойлох зорилт гурван асуултанд төвлөрч байна. 1. Социологи нь ямар үзэгдлийг судалдаг вэ?; 2. Яагаад эдгээр үзэгдлийг судлахад тусгай салбар ухааныг гаргахыг шаарддаг вэ?; 3. Социологи нь бусад шинжлэх ухаантай ялангуяа нийгмийн шинжлэх ухаануудтай харилцах харилцаа ямар байх вэ? г.м болно.

Энэ асуудлыг товчхон шийдвэрлэхийг хичээе.

Социологийн судалгааны объектыг тодорхойлох нь бусад бүх шинжлэх ухааны нэгэн адил судлах зүйлийн баримт сэлтүүдийн бүлэглэлийг тогтоох, өөрөөр хэлбэл судалж буй үзэгдлийн тухай бусад шинжлэх ухаанаас ялгагдах онцгой байр суурь, үзэл бодлыг олох явдал юм.²

¹ Сонин уншиж, намын хөтөлбөрийг судалж, улс төрчдийн яриаг сонсож байхад хүмүүс “нийгэм”, “нийгмийн”, “социаль”, “социологийн” гэсэн ойлголтуудыг энгийн түвшинд ямар олон янзаар ойлгодог юм бэ. Энд эдгээр үгнүүдийг зохиогч өөрийн ойлголтоор авч үзэх эсвэл ихэнхдээ бүр ойлголтгүй байх юм. Улс төрийн намуудын хөтөлбөрт болон улс төрчдийн ярианд “нийгмийн /социаль/” гэдгийг “улс төрийн” эсрэг сөргүүлэн тавих явдал энгийн үзэгдэл болжээ. Тухайлбал нийгмийн /социаль/ хувьсгалыг улс төрийн хэмээж, нийгмийн /социаль/ өөрчлөлтийг улс төрийн өөрчлөлт болгодог. Мөн улс төрийн намын хөтөлбөрт ийм сөргүүлэн тавих зүйл их байна. Жишээ нь, хөдөө аж ахуйн болон хөдөлмөрийн өөрчлөлтүүдийг яагаад ч юм социаль өөрчлөлт хэмээж харин төрийн бүтцийн өөрчлөлтийг яагаад үүнд хамааруулан авч үздэггүй юм бэ. Ихэнхдээ нийгмийн /социаль/ гэдгийг эдийн засгийн гэдэгтэй адилтгаж байдаг, тиймээс ч нийгэм-эдийн засгийн хөтөлбөр, шинэчлэл гэж ярьдаг шүү дээ. “Социаль” гэсэн ойлголт нь “нийгмийн” гэсэн ойлголтоос ялгаатай юм. Товчхондоо, эдгээр ойлголт ухагдахууныг ямар ч эмх цэгцгүй, замбараагүй хэрэглэж байна. Энэ байдлыг Waxweiller’a. Esquisse d’ une Sociologie. 1906. 67-72 талаас харж болно.

² Энэ хэсэгт “объектыг тодруулах” болон “өвөрмөц үзэл бодлоо тогтоох” хоёр нь ижил утгатай гэж зөв зааж өгсөн Е.В.Де-Роберти, Ваксвейлер, Зиммель, Гумплович, Франкийн саналтай нийлэхээс өөр аргагүй юм. “Үзэл бодол бол хамгийн чухал” гэж Ваксвейлер тэмдэглэжээ.

Социологийн объектын тухай асуултын товч хариултыг урьдчилан дараах байдлаар илэрхийлье. *Социологи нь нэг талаас хүмүүсийн хоорондын нэг нэгэнтэйгээ харилцах харилцааг нөгөө талаас эл харилцаанаас үүдэлтэй үзэгдлүүдийг судалдаг.*

Энэхүү тодорхойлолтоос харахад социологийн судалдаг бүлэг асуудлууд тодорч байна. Тиймээс харилцан үйлдлийн бусад бүх хэлбэр, төрлүүд социологийн судалгааны хүрэнээс гадуур байна. Органик биш биетүүд мөн түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох амьтан, ургамлын харилцааны үйлдлийн тухай мэдээ баримтууд социологийн судалдаг хүрээнд ордоггүй. Бидний социологи бол homo-социологи юм. Тэр нь зөвхөн хүмүүсийн хоорондын харилцааны тухай өгүүлдэг.

Социологийн судлах зүйлийг зөвхөн дан ганц харилцаагаар үйлдлээр тодорхойлох нь хангалтгүй болохоор *хүмүүсийн хоорондын харилцан үйлдэл* хэмээх нэмэлт шинж чанарыг оруулдаг. Ингэснээр тоо томшгүй олон үзэгдэл, үйл явдлаас тодорхой бус зүйлийг тусгаарлаж улмаар нарийн нягт хийгээд илэрхий хил хязгаартай тодорхой бүлэг, төрлийг гаргасан.

§2. Социологи бие даасан шинжлэх ухаан болж орших үндэслэл

Социологийн объектын тодорхойлолтыг бүрэн тодорхой болгоход шаардлагатай нэмэлт нөхцөлүүдийг хөндөлгүйгээр өөрсдөөсөө нэгэн асуултыг асууя. *Хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг судалгааны онцгой бүлэг болгож, мөн түүнийг судлахад тусгай онол гаргаж бие даасан шинжлэх ухаан бүтээх үндэслэл байна уу?* Бид энэ тохиолдолд Л.И.Петражицкийн хэлснээр “арван лот жинтэй навчин тамхины”³ тухай тусгай шинжлэх ухаан бүтээх гэсэн хүнтэй адил алдаанд орох юм биш биз. Онолын тэнцвэртэй зарчим болон оюун бага зарцуулах зарчмын эсрэг бид алдаа гаргах юм биш үү? Тусгай төрөл зүйл бий болгоход учир шалтгааны хязгаарлал байхгүй шүү дээ. Үүнд: нэг нь “арван лот жинтэй навчин тамхи”, нөгөө нь “таван ямх өргөнтэй мод” (ямх-4,4 см орчим. Орч. Т.Б), гуравдахь нь “үс сахлаа хусдаг хүмүүс”, дөрөвдэх нь “бэлхүүсний даруулга зүүдэг эмэгтэйчүүд” г.м төрөл зүйлийг гаргаж байдаг. Эдгээр бүлэг үзэгдлүүдэд тус бүрт нь зориулан тусгай ухаан бүтээвэл юу болох билээ! “Элдэв янзын хувилбарууд маш их боловч оюун ухааны санах ойн чадвар хязгаартай учир мэдлэгийн энэхүү илүүдлүүд нь бидэнд хүндрэл учруулах болно. Хуримтлагдсан эл зах хязгааргүй мэдээллийн өмнө бид хүчин мөхөсдөх болно” хэмээн А.А.Чупров маш зөв зүйтэй онцлон тэмдэглэжээ⁴.

(Франк. Философи ба амьдрал. 284-285; Гумплович. Programme de Soziologie. Annales. T.1. 104; DeRoberty. Sociologie et Psychologie. Annales. T.X. 108; Waxweiller. Esquisse d' une soziologie, 39; Simmel. Sociologie. 1908)

³ “Ерөнхий логик сэтгэлгээний үзлийн үүднээс үзэхэд анги болон ангийн тухай ойлголтууд шинжлэх ухаанд ач холбогдолтой үнэ цэнэтэй байдаг” гэж Л.И.Петражицкий тэмдэглэжээ. Жишээ нь: ангилалын хувьд “10 лот жинтэй навчин тамхи”, “урт сүүл, богино хүзүүтэй нохой” гэх мэтээр зузаан ботиудыг дүүргэж болох олон тооны “үнэнүүдийг” дурьдаж болно. 10 лот жинтэй навчин тамхины хувьд тэр нь дэлхийн татах хүчинд автаж, уналтын явцад хурдсах тэрхүү хуулинд захирагддаг (ерөнхийдөө механикийн болон физикийн агуулгыг харьцуул), улмаар тэдгээрийн химийн бүтцийн хувьд олон үнэн баримтуудыг дэвшүүлж болно. Бидний төсөөлж буй шинжлэх ухааны дараагийн боть болох “10 лот жинтэй навчин тамхины тухай”-г биологийн шинжтэй үнэнээр бүрдүүлж улмаар ургамлын шинжтэй тусгай үнэнээр бүрдүүлж болно. Ийм өргөн хүрээтэй “шинжлэх ухаан”-ыг “урт сүүл, богино хүзүүтэй нохдын” болон “тугалган цэргүүдийн” хувьд бий болгож болно. Гэхдээ энэ шинжлэх ухаанууд нь (Петражицкийн зөв дүгнэснээр) шинжлэх ухааны дууриамал болох ба онолыг ингэж бий болгохгүй байх бодит жишээ юм. Эдгээр онолын шинжлэх ухаанч бус шинж нь түүнд яригдаж буй зүйлүүд нь бодит бус, дэндүү явцуу ангилалд хамаарч байна, харин энэ нь илүү өргөн ангилалд хамаарах ёстой. Жишээ нь: үрэлтийн болон дэлхийн татах хүчний тухай онолыг зөвхөн навчин тамхины тухайд бүр тодруулбал “10 лот жинтэй навчин тамхины” хувьд ярьсан боловч үнэн хэрэг дээрээ бүхий л физик биетүүдэд хамааралтай юм. Өөрөөр хэлбэл, илүү өргөн хүрээтэй юмсын ангилалд багтах ёстой. Ийм онолууд нь юмсын мөн чанарыг бүдэгрүүлж, энэхүү ангилалд багтаж буй юмсын шинж чанар нь зөвхөн түүнд тусгайлан хамаарагдах өвөрмөц шинж гэж алдаатай санал бодлыг үүсгэхэд хүргэж төөрөгдөлд оруулдаг. Петражицкий. Эрх зүй ба ёс суртахууны удиртгал. СПб. 1907. 72. 75-77.

⁴ Чупров А.А. Статистикийн онолын тухай өгүүлэх нь. СПб., 1909. Түүний 1-20 талаас хүч бага зарцуулах зарчмын ач холбогдлын тухай хар. Макс. Танин мэдэхүй ба төөрөгдөл. Скирмунт хэвлэлийн газар. 459 тал; Риккерт. Байгаль шинжлэлийн ойлголтын үүслийн хил хязгаар. Воденийн орчуулга.

Дээр өгүүлсэнтэй уялдан дараах асуулт гарч ирж байна. Үүнд: *хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг судлах зорилготой социологи хэмээх тусгай шинжлэх ухааныг бүтээх хангалттай үндэслэлүүд байна уу?*

Энэхүү асуултын хариулт нь гурван асуудлыг шийдвэрлэхээс хамаарна. Үүнд:

1. Социологийн судлах үзэгдэл үйл явцын төрөл анги хэр чухал болох; 2. Тэр нь sui generis үзэгдэл мөн үү, бусад төрлийн үзэгдэлд байхгүй шинжийг агуулж чадаж байгаа эсэх; 3. Социологиос өмнө байсан шинжлэх ухаануудаар судлагдаж байсан эсэх ба ингэхгүй бол түүнийг бие даасан шинжлэх ухаан болгох нь илүүц юм.

Социологийн практик ба онолын ач холбогдол

Эхний асуултын зөв зүйтэй хариултыг батлах хэрэг байна уу. Хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг судлахын ач холбогдол нь судлахад бидний гүн гүнзгий судлах сонирхолтой холбоотой. Бид эдгээр үзэгдлийг практикийн үүднээс танин мэдэх шаардлагатай юм. Шинжлэх ухаан нь амьдралын төлөө тэмцлийн нэгэн зэвсэг байсаар ирсэн учраас энэ утгаараа ч гэсэн хүмүүсийн хоорондын харилцааг судлах салбарт гээлгүй хадгалагдсаар ирсэн билээ. Товчхондоо, хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг судлах практик ач холбогдол эргэлзээгүй юм.

Үзэгдлийг тусгайлан судлах онолын ач холбогдол үнэ цэнийг гаргах нь дээр дурьдсан сүүлийн хоёр асуултын шийдлээс хамаарна. Хэрэв бусад төрлийн харилцааны үйлдэлд байхгүй шинж чанарыг өөртөө агуулсан sui generis-ийн үзэгдлийн гол учир утга нь хүмүүсийн хоорондын харилцан үйлдэл бол тусгай төрөл анги үүсгэх ба энэхүү төрлийн хувьд шинжлэх ухааны тусгай онолыг боловсруулах хангалттай үндэслэл болно. Эл тохиолдолд зөв боловсруулсан онол нь бодит байж хүч чадал хэмнэх зарчимд харшлахгүй болно. Хэрэв энэхүү үзэгдлийн төрөл ангийг бусад шинжлэх ухаан судлаагүй бол эл нөхцөл нь дээрх үзэгдлийг судлах тусгай шинжлэх ухаан бүтээх учир зүйн хангалттай үндэслэл болдог.

Социологи ба физик химийн шинжлэх ухаан

Хүмүүсийн хоорондын харилцан үйлдэл нь бусад бүх төрлийн органик ба органик бус харилцааны үйлдлээс өөр sui generis үзэгдлийг агуулдаг хэмээн хэлж болох уу? Магадгүй үүний үндэс нь физик-химийн болон органик үйл явц байж болох юм. Мөн холын ирээдүйд шинжлэх ухаан нь эдгээрийг органик үйл явц руу ойртуулж, хүмүүсийн хоорондын харилцааны нарийн ертөнцийг физик, химийн хуулиар тайлбарлаж болзошгүй юм. Ямар ч байсан өнөөдрөөс түүн рүү тэмүүлэх ёстой. Гэхдээ энэ нь шударга судлаачид одооноос эхлэн хүмүүсийн хоорондын харилцааг физик-химийн болон биологийн шинжлэх ухааны хуулиар тайлбарлаж болно гэсэн утгатай юм уу?

Үнэн сэтгэлээсээ шударга байцгаая. Энэхүү эрмэлзэл нь үндэслэл багатай бөгөөд хандлагын шинжтэй хлестаковч үзэл болно. Харамсалтай нь одоохондоо шүү. Ийнхүү оролдовч хэн ч үр дүнд хүргээгүй бөгөөд ойрын хугацаанд амжилтанд хүрч чадахгүй. Үнэндээ ийм оролдлогууд байсан, одоо ч байсаар байна. Гэхдээ хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг физик-химийн болон биологийн энгийн журманд захируулж болохгүй байгааг нотлох нэг үзүүлэлт болж байна.

Өнөө үед ийм оролдлогыг В.Освальд, Solvay'a, Воронов, Haret ба Ant. Portuendo у Barcelo нар хийжээ. В.Освальд, Solvay'a, Воронов нар нийгмийн үзэгдлийг эрчим хүчний ухагдахуунаар тайлбарлахыг оролдож, физик-химийн үзэгдэл мэтээр үзэж байв. Үүнээс ямар үр дүн гарав? "Ухамсар нь мэдэрэл, эрчим хүчний үйл явцын урсгал мөн", "дайн, гэмт хэрэг, шийтгэл бол эрчим хүчний алдагдал", "худалдах, худалдаж авах явдал нь солилцооны урвал (Освальд⁵), "хамтын ажиллагаа бол хүчнүүдийн нийлбэр", нийгмийн тэмцэл бол "хүчнүүдийн ялгавар", уналт бол хүчнүүд задрах" ба "хүчний харилцаа" г.м хэд хэдэн томъёоллыг бид харж болно.⁶ Энэ нь зөв байж мэднэ.

Гэхдээ ийм харьцуулалтаар бид нийгмийн үзэгдэл болон хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг танин мэдэхэд их зүйлийг олж авч чадаж байна уу? Ямар ч байсан социологи дахь "органик сургаал чиглэл"-ийн харьцуулалтаас илүү зүйл олж авч чадахгүй юм. Эдгээр томъёолол ба харьцуулалт нь сайндаа л трюизм бөгөөд муугаар бодвол оновчгүй харьцуулалт юм.

Хүмүүсийн хоорондын харилцаа, зан төлөвийг физик үзэгдлийн энгийн механик хуулиар тайлбарлаж, "социаль механикийн" бүтээх оролдлогын хувьд дээрх дүгнэлтийг мөн хийж болно. Haret ба Antonio Portuendo у Barcelo нарын хийсэн оролдлого нь үүний жишээ болж байна. Тэд нар "хэрэв бүх

⁵ В.Освальд хар. Байгалийн философи. СПб., 1903; Die energetischen Grundlagen der Kulturwissenschaften. Leipzig. 1909; Solvays. Note sur les formules d' introduction a l'energetique physio-et psychosociologie. 1906.

⁶ Вороновыг хар. Социологийн үндэслэл.

төрлийн хүчинд механикийн хууль, зарчим тохирдог болдог сэтгэл зүйн болон нийгмийн хүчинд ч таарах ёстой" хэмээх үзлийг үндэс болгосон.⁷

Үүний дараа тэд механикийн ойлголтуудыг хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд зөөвөрлөх ажилдаа орсон. Бие хүн "материаллаг цэг" болон хувирч, түүнийг хүрээлэн буй хүмүүс "хүчний талбай" болдог байна. Энэхүү тогтсон хандлагын хойноос дараах хуулиуд гарч ирнэ. Үүнд: "бие хүний хөдөлгөөнт эрч хүч ихсэх нь далд буюу болзолт идэвх хүч багасахтай тэнцэнэ"⁸, "t1 агшинд буй нийгмийн бүлгийн үйл ажиллагааны хамтын эрчим хүч нь анхны t0 агшинд байсан эрч хүч болон бие хүн, бүлэгт нөлөөлдөг хөндлөнгийн бүх хүчийг бий болгосон тэр завсрын үед байгаа (t1-t0) үйл ажиллагааны нийлбэртэй тэнцүү байна"⁹ г.м болно.

Энэ бүгд зөв боловч "нийгмийн механикийн хуулиуд" гэгчээр бид ямар шинэ зүйл олов? гэсэн асуулт гарна. Сайнаар ярих юм бол триизмыг, муугаар ярьвал "10 лот жинтэй навчин тамхины тухай" "шинжлэх ухаантай" төстэй онол, хуулиуд гаргаж авна. "Хүний бие махбодь нь эрхтэн хийгээд материаллаг бүрдэл хэсгүүдийн цогц нийлбэр байдаг бөгөөд физикийн механикийн хуулинд захирагддаг" ба "хичнээн хүсэвч татах хүчний хуулийн болон физикийн механикийн бусад бүх хуулийн үйлчилгээнээс өөрийгөө яагаад ч гаргаж чадахгүй (se soustraire)" хэмээх A.Barcelo-гийн хэлсэн үгэнд эргэлзээгүй үнэн агуулагдаж байна. Үүнээс харахад физикийн механикийн хуулийг хүнд хамааруулан *материйн энгийн нийлбэр мэтээр үздэг* тусгай салбар ухаан бүтээх нь утгагүй бөгөөд ашиггүй юм. Мөн чанараараа энэ нь бүхий л физик биетүүдийн адил физикийн хуулинд захирагдаж байдаг билээ. Гэхдээ энэ тохиолдолд хүмүүс бол амьгүй биетээс ялгагдах зүйлгүй энгийн материаллаг эд болж байна. Хүнийг илтгэх бүхий л өвөрмөц шинж, хүн ба органик бус биетүүдийг ялгаруулах тэр зүйлүүд энэ үед алга болсон байна. Ийм танин мэдэхүй нь нийгмийн үзэгдлийг sui generis үзэгдэл болохын хувьд танин мэдэхэд юугаар ч туслахгүй. "Хэрэв эрхзүй нь "хүчнүүдийн харьцаа" юм бол жинлүүрийн хоёр талд буй А болон В ачааны хүчний харьцаанаас юугаараа ялгаатай юм бэ? Энд хүчнүүдийн тэрхүү харьцаа үйлчилж байна шүү дээ. Гэвч үүнээс А ба В ачаа, хүчний харьцаа бол эрхзүйн харилцаа гэх зүйл гарч ирэх уу? Цацрагийн тусламжтай дулаан бууралт ба гэмт хэрэг нь эрчим хүчний эрдэмтдийн хэлдгээр "эрчим хүчний алдагдал" юм байна. Гэхдээ ямар ч эрчим хүчний бууралт нь гэмт хэрэг байдаг гэж үү."

"Нийгмийн үзэгдлийг судлах эл судалгаа нь хүмүүсийн нийгмийн харилцааг судлах бус харин хүмүүсийг энгийн *физик биет* болохын хувьд судлаж байгаа хэрэг болно."¹⁰ Гэхдээ хүмүүс бол физик биет байхын зэрэгцээ санаа сэтгэл, сэтгэц, ухамсарыг агуулдаг амьд биетүүд юм. Хэрэв амьд бие махбодь органик бус материас ялгаатай бол, хэрэв амьдралын үйл явцыг одоо болтол физик-химийн үйлдэлд тааруулж чадахгүйгээр биологийн оршин байх үндэслэл болж байгаа тохиолдолд ухамсрын дээд хэлбэрийг агуулдаг хүмүүс органик бус биетээс улам бүр ялгаатай байж, тэдгээрийг амьгүй материйн харилцаанд тохируулахад их хүндрэлтэй байдаг юм. Ийм учраас хүмүүсийг энгийн материаллаг биетүүдийн харилцаа мэтээр бус харин түүний *харилцан үйлдлийн өвөрмөц баялаг агуулгыг* судлах тусгай шинжлэх ухааныг бий болгох хангалттай үндэслэл байгаа болно. Тэднийг зөвхөн физик биет болохын хувьд авч үзэх оролдлого нь физикийн үүднээс зөв боловч хүмүүсийн харилцан үйлдлийг танин мэдэж чадахгүй харин судлах зүйл бус хэмээн орхидог юм. Физикийн хувьд хүн байдаггүй харин зөвхөн "материаллаг биетүүд" л байна. Энэ тохиолдолд гавьяа зүтгэл, гэмт хэрэг, сайн ба муу зүйл, хайр дурлал, үзэн ядалт, хараалын ба өршөөлийн уг байхгүй харин зөвхөн "биетүүд" ба "хөдөлгөөн" л байна. Түүний микроскоп, телескоп, спектроскоп хичнээн сайн байсан ч хүний харилцааны үйлдэл дэх үнэн зөв, сайн сайхан зүйл, аллага, авралыг олж харж чадахгүй юм.

Бид эдгээр үзэгдлүүдийн хязгааргүй олон янз зүйлийг танин мэдэхийг хичнээн хүсэвч хүмүүсийн харилцааны мөн чанар нь физик-химийн шинжлэх ухааны судлах зүйлээс холдоод явчихдаг учир эл үзэгдлүүдийг судлах тусгай шинжлэх ухаан бий болох үндэс суурийг тавьдаг.

Үүнээс гадна хүмүүсийн харилцан үйлдлийг физик-химийн үйл явцад захируулж чадсан ч хүмүүсийн харилцааны үйлдэл нь органик бус ертөнцийн харилцан үйлдлээс ялгагдах sui generis үзэгдэл хэвээр үлдэх болно. Энд mutatis mutandis хэмээн Отто Глезерийн биологийн асуудлаар хэлсэн үгийг давтаж болох юм. "Амьд шим ертөнцийн үйл явцын талаархи цэвэр физик-химийнх нь мөн чанарын нотолгоо нь бодит байдлаасаа ялгаатай гэж үзэх шаардлагагүй юм хэмээн тэрбээр бичжээ. Юмс үзэгдлийг шинжлэх явцад зарим шинж чанарыг хасдаг уу хэмээх асуулт үнэндээ хий хоосон зүйл юм. Гэвч амьдралын нөхцөл байдлыг физик-химийн үндэстэй гэж үзэх нь эцсийн эцэст амьд юмс нь амьгүй гэж заахад хүргэдэг. Анатомийн болон гистологийн судалгаагаар энэ амьтан бол үхэр юм гэж хэлж өгч чадахгүй. Хэрэв бид түүний эд эсийг химийн үндсэн элементээр судалж үүндээ ханалгүй улмаар бүр морь нь бүхэлдээ электроноос бүрддэг гэж үзэх хүртэл шинжилгээ хийсэн ч гэсэн морь бол морь гэдгийг яаж үзүүлэх вэ? Хэрэв юмсын ялзал нь шинжилж буй юмсын шинж чанарыг орхигдуулдаггүй юм бол

⁷ A.Y.Barcelo. Mecaniqui sociale. Revue internat de Sociologie. 1915. 492; Haret. Sociale mecaniqui. 1910. Өмнөтгөл ба passim.

⁸ Мөн тэнд. 567.

⁹ Мөн тэнд. 576.

¹⁰ Сорокин. Гэмт хэрэг ба шийтгэл, гавьяа ба шагнал. СПб., 1904. 43-44. Энэ асуудлаар энд дэлгэрэнгүй хар. 42-43 тал.

тэдгээр нь ганц нэгхэн болон өвөрмөц гэдэг нь ойлгомжтой, мөн ялзрах үйл явц дууссаны дараа ч тэр мөн түүнээс ч өмнө ганц нэгхэн л байсаар байх болно. Эцсийн дүндээ амьд юмс ганцхан уу, өвөрмөц үү эсвэл үгүй юу гэсэн ганц асуулт байна. Энэ асуултанд зөвхөн зөвшөөрсөн хариулт өгч болох юм.”

“Хэрэв хүмүүс тэдний харилцаа нь бүхэлдээ электроноос бүрдэж, түүний үйл ажиллагаанаас хамаарч байгаад бидэнд харуулбал хүн бол хүн биш гэдгийг яаж харуулах билээ. Эцсийн дүндээ хүмүүс ганцхан үү, өвөрмөц үү, органик биш биетүүдээс ялгаатай юу эсвэл үгүй үү гэсэн ганц асуулт байна. Энэ асуултанд зөвхөн зөвшөөрсөн хариулт өгч болох юм” хэмээн Глезерийн үгийг арай өөрчилсхийн хэлж болох юм.

Зохих өөрчлөлтүүд бүхий органик биш биетээс хүн ялгагддаг тухай яригдсан бүх зүйлүүдийг мөн амьтан, ургамал зэрэг бусад биетүүдээс ялгаатай гэдэгт хэрэглэж болно. Мэдээж, homo-sapiens-ийн төлөөлөгчид нь амьд биетүүд, эдгээрт биологийн хууль үйлчилнэ. Хүн зөвхөн амьд биет төдийгүй бусад биетүүдэд байхгүй шинж чанар болох сэтгэхүй, ухамсар, оюун ухаан заяасан амьтан юм. Энэ утгаараа тэд ганцхан ба өвөрмөц юм.¹¹ Үүний хүчинд тэдний харилцаа нь бусад биетүүдийн харилцаанаас ялгаатай байдаг. Одоо болтол хүнийг амьтантай адилтгаж болохгүй юм. Бүр ямартаа ч хүний нийгэм-сэтгэл зүйн харилцааг бүхэлд нь биологийн үйл явцад хамааран үзсэн ч гэлээ “хүний талаарх анатомийн болон гистологийн шинжилгээ нь нэг эст амьтны мөн чанар хүн гэж харуулж чадахгүй, хүнийг хүн биш гэсэн дүгнэлтэнд хүргэж үл чадна.”

“Ухамсрын нийгэм-сэтгэл зүйн харилцааны гайхамшигтай үйл явц нь хүнийг биологи судалдаг ертөнцөөс холдуулж, бидний бие даасан шинжлэх ухааны өвөрмөц үндсийг бүрдүүлдэг. Бие даасан байдал нь зогсонги, туйлын зүйл биш, харин бие даасан физик, хими, астрономи, геологи, биологийн ухаан шиг цэвэр практикийн зүйл юм¹²” хэмээн мөн л Глезерийн үгийг арай өөрчилсхийн хэлж болох юм.

Социологи ба биологи, түүнчлэн экологи

Энэхүү нөхцөл байдлыг сүүлийн үед гарч ирж буй биологийн салбар шинжлэх ухаанууд ганхуулж чадахгүй. Энэ нь амьтан болон ургамлын хоорондын харилцааны үйлдлийг судалдаг экологи эсвэл зоо-фито-социологи юм. Яагаад ганхуулдаггүй вэ гэвэл, нэгдүгээрт, хүмүүсийн хоорондын харилцааг амьтан ба ургамлын биологийн харилцаанд нийлүүлдэггүй; хоёрдугаарт, харилцааны үйл явц нь нэг талаас амьтдын хоорондын харилцаа, нөгөө талаас ургамлын хоорондын харилцаа нь үлэмж ялгаатай байдаг учраас зоо-социологи ба фито-социологи хэмээх тусгай ухааныг бүтээхийг шаардаж байна. Тиймээс homo-социологи нь биеэ даан орших бүхий л үндэслэл бий; гуравдугаарт, социологи дахь “биологийн сургааль”-ийн нийгмийн үзэгдлийг биологитой холбох гэсэн оролдлого амжилтгүй болсон; дөрөвдүгээрт, homo-социологийг биологитэй нэгтгэхийг оролдож буй судлаачид жишээ нь Ваксвейлер хүмүүсийн хоорондын харилцааг бусад биетүүдийн харилцаанаас ялгагдах бие даасан ангилалд оруулж, социологи хэмээх тусгай шинжлэх ухааныг бүтээх хэрэгтэй болов¹³. Энэ нь маш чухал юм. Тэгээд ч Ваксвейлерийнхээр социологийг биологид хамааруулах уу эсвэл түүнийг бие даасан ухаан гэж үзэх үү гэдэг нь үнэн чанартаа тийм ч чухал биш юм. Тийм ч учраас нэг талаас зоо болон фито-социологичид нөгөө талаас социологичид эрх мэдэл, байр сууриа булаацалдаж сөргөлдөлгүйгээр гайхамшигтай хамтран ажиллаж чадна.¹⁴

Бусад бүх харилцаанаас ялгаатай хүмүүсийн хоорондын харилцаа нь sui generis-ийн үзэгдлийн мөн чанар болно гэж дээр яригдсан зүйлээс хүлээн зөвшөөрч болох юм.

¹¹ Энэ тухай доороос хар.

¹² Глезер. Мөн гэнд. 80.

¹³ Waxweiler. Op. cit. 1-87.

¹⁴ Фито болон зоо-социологийн тухай хар: Сукачев. Ургамлын аймаг судлалын удиртгал. СПб., 1905. Henslow. L'ecologie au point de vue de l'evolution des vegetaux. Scientia. Хавсралт. 87-107; Морозов. Ой ургамлын аймаг болох нь. СПб., 1913; Манай ойн төрлийн биологи; Вагнер. Ургамал судлал дахь социологи. (Байгаль. 1912. 9-р сар); Нийгмийн үзэгдлийг фикик-химитэй тэгшгэх гэсэн яаруу оролдлогыг шүүмжилсэн миний энэхүү шүүмжийг “тодорхой шинжлэх ухаан дахь” үзэгдлийг судлах механик тодорхой аргыг шүүмжилсэнтэй адилтгаж ойлгохгүй байхыг уншигчдаас хүсч байна. Байгалийн шинжлэлийн тодорхой ухааны аргаас ялгаатай социологи ба нийгмийн ухаанд хэрэглэгдэх өвөрмөц аргуудыг бүтээх гэсэн “нормативист”-ын төлөөлөгчдийн амжилтгүй оролдлогыг бодвол байгалийн шинжлэлийн болон нийгмийн ухааны аргууд нь нэгдмэл гэдгийг би хатуу зөвшөөрч байна. Байгалийн шинжлэлийн замаар явж буй социологи нь шинжлэх ухааны хувьд хөгжин дэвшиж чадна. Аль аль шинжлэх ухааны судалгааны арга нь бус объект нь хоорондоо ялгаатай юм.

*Хэрэв хүмүүс ба тэдний харилцааг физикийн үүднээс энгийн “хүчнүүдийн төв” эсвэл “материйн цогц” хэмээн үзвэл физик химийн шинжлэх ухааны судлагдахуун болно, харин түүнийг амьд биет гэж үзвэл биологийн судалгааны мэдэлд очно, sui generis-ийн үзэгдэл болох хүмүүсийн хоорондын харилцаа нь одоохондоо физик химийн ч, биологийн ч судалгаанд хамаарахгүй, тиймээс бидний нэрлэж буй социологи буюу *hoto-социологи* гэх өвөрмөц шинжлэх ухааны оршин тогтнох үндэслэлийг бий болгож байна.*

Хэрэв бид хүмүүсийн энэхүү өвөрмөц харилцааг өөр ямар ч шинжлэх ухаан судалдаггүй болохыг харуулж чадвал социологи оршин тогтнох нь хүлээн зөвшөөрөгдөнө. Одоохондоо нийгмийн шинжлэх ухаануудыг авч үзэхээ азная.

Дээр хэлэгдсэн зүйлийн дараа хүмүүсийн хоорондын харилцаа нь бусад органик бус биетүүдийн харилцаанаас ялгаатай болон физик химийн шинжлэх ухаанууд ялангуяа механик физик судалдаггүй болохыг дэлгэрэнгүй батлах хэрэг байна уу даа.

Биологийн үүднээс асуудлыг авч үзэх нь арай хүнд байна. Хэрэв хүмүүсийн хоорондын харилцааг биологийн салбар ухаан болох морфологи, анатоми, физиологи судалдаггүй харин *хүний бие бялдрын гадаад болон дотоод үзэгдлийг судалдаг* нь илт байгаа тохиолдолд биологийн салбар болох *экологийн хувьд өөрөөр ярьж болох юм.* “Теккелийн тодорхойлсноор экологи нь *хүрээлэн буй гадаад орчинтойгоо биетүүдийн харилцаж буй харилцааг судалдаг* шинжлэх ухаан буюу оршин амьдрах нөхцөлийн цогц нийлбэрийг судалдаг ухаан. Энэ нөхцөлийн зарим хэсэг нь органик, зарим нь органик бус юм.” Үүнтэй зохицолдон экологи нь *нэгдүгээрт, огторгуйн (органик бус) орчинтойгоо биетүүдийн харилцах харилцааг, хоёрдугаарт органик орчинтойгоо биетүүдийн харилцах харилцааг, өөрөөр хэлбэл биетүүдийн хоорондын харилцааг судалдаг.*¹⁵

Дээр дурьдсанчлан өнөө үед биетүүдийн хоорондын харилцааг судалдаг экологийн энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дотроо хоёр салбарт хуваагддаг. Үүнд: амьтдын хоорондын харилцааг судалдаг *зоо-социологи* (амьтдын бүлэг) ба ургамлын хоорондын харилцааг судалдаг *фито-социологи* (ургамлын бүлэг) юм.¹⁶

Үүнээс харахад экологийн судалгааны объект нь социологийн судлах зүйлтэй төстэй байна. Аль алинд нь биетүүдийн харилцан үйлдлийн баримтуудыг судалдаг. Мөн аль алинд нь биетүүдийн харилцааны үйл явцыг судалдаг (*homo-sapiens* ч мөн биет юм.)

Тиймээс социологи нь экологид шингэж байна уу? Экологийн өмнө эзлэж байсан байр суурийг социологи эзлэх гээд байгаа юм биш биз? Социологиос гадна хүмүүсийн хоорондын харилцааг экологи судалдаг уу?

Эдгээр асуултын хариулт ийм байх ёстой. *Хэрэв хүмүүс нэг эст амьд болон бусад биетээс ялгаагүй юм бол*, хэрэв тэдгээр нь өвөрмөц шинж чанар болох сэтгэцийн шинжийг агуулдаггүй юм бол, хэрэв тэдний зан үйлдэл ба сэтгэц нь тропизм болон дэслэл, энгийн протоплазмын цочрол ба рефлексийн хариу үйлдэлд хамаарах юм бол, хэрэв хүмүүсийн харилцааны ертөнцийг бусад биетүүдийн харилцаатай адилтгаж байгаа юм бол, хэрэв *хүн болон нэг эст амьд, бусад биетүүд болох амьтан, ургамлын хооронд тэнцүүгийн тэмдэг тавих юм бол тиймээ, өвөрмөц hoto-социологийн хэрэг байхгүй*, хүмүүсийн хоорондын харилцаа бүхлээрээ зоо болон фито-социологид багтана.

Хэрэв хэрэг байдал өөрөөр тавигдвал, хэрэв нэг талаас хүн, нөгөө талаас шоргоолж, загас, сармагчингийн бүлгийн хооронд тэнцүүгийн тэмдэг тавьж болохгүй юм бол, хэрэв *homo-sapiens*-ийг ургамалтай, мөн хүний нийгмийг нэг эстүүдийн бөөгнөрөл, шоргоолжны сүрэг, зөгийн үүр буюу нэг үгээр хэлбэл ойтой адилтгаж болохгүй юм бол хариулт өөрөөр тавигдана. Тэгвэл хүмүүсийн харилцааны ертөнцийг өөр өвөрмөц ангилалд оруулах ёстой, зоо болон фито социологиос гадна *homo-социологийг* бүтээх хэрэгтэй болно. Тиймээс зоо болон фито социологиос гадна *homo-социологи* оршин байх нь зайлшгүй юм.

Хоёрдмол байдлыг шийдвэрлэлээ, түүнд эргэлзэх зүйл байхгүй. Биологичид өөрсдөө бүр Леба хүртэл, мөн хүнийг машинтай адилтгадаг бусад механикийн туйлын үзэлтнүүд машин бол *sui generis* гэж хүлээн зөвшөөрч байгаа, харин үүнээс улбаалан судалгааны өвөрмөц шинжлэх ухааныг шаардсан хүмүүсийн хоорондын харилцааны үзэгдлүүд нь үзэгдлийн тусгай ангилал үүсгэж байна. Бүхэлдээ Лебагийн зарчим болон биологи дахь бусад механикийн туйлын үзэлтнүүдээс эх үндсээ авч социологийг биологийн хэсэг хэмээн бүтээхийг оролдсон Ваксвейлер экологийн үзэгдлүүдээс хүмүүсийн хоорондын харилцааны үзэгдлийг ялгахад хүрч, улмаар түүнийг өвөрмөц ангилалд оруулахдаа социологийг экологийн нэгэн тусгай салбар болгожээ.¹⁷

¹⁵ Hatzkel. *Generelle Morphologie der Organismen*. T.1., 1966. 286.

¹⁶ “Нийгмийн гишүүдийн хоорондын харилцааг судалдаг социологитой харьцуулбал манай мэдлэгийн салбар нь мөн л ургамлын бүлгийн дотоод харилцаа холбоо, тэдний төрөл хэлбэр, үүслийг судалдагаараа фито-социологи гэж үзэж болно.” Сукачёв. Ургамлын аймаг судлалын удиртгал. СПб., 1905. 119-120.

¹⁷ *Esquisse d' une Sociologie*. 51-87. Ургамлын харилцааны ертөнцөд *affinitesocial*-ийн үл мөр алга байна гэж тэрбээр хэлжээ. 72. *Sociabilite* нь зөвхөн хүнд хамааралтай гэж Ваксвейлер цааш нь бичжээ. Үүнээс хамааран “хүн ба амьтны харьцуулсан социологи нь хүний тухай цэвэр

Социологийг экологийн онцгой салбар гэх үү эсвэл бие даасан ухаан гэх үү гэдэг нь үнэн чанартаа тийм ч чухал биш харин экологийн ямар ч үйл явцтай төсөөгүй судлаж буй үзэгдэл нь өвөрмөц гэдэг л хамгийн чухал юм. Социологийг экологийн салбар гэж үздэг хүмүүс ч энэхүү баримтыг тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрч буйг харж байна.

Хэрэв амьтны болон ургамлын ертөнц дэх харилцаа нь тэднийг зоо болон фито социологид салгасан бол амьтан ба ургамлын харилцааны хэлбэрээс эрс ялгагдах баримтыг судалдаг homo-социологийг ялгах хангалттай үндэслэл байна. Тийм ч учраас механист болон виталистуудын үзэл бодлын үүднээс сэтгэл амар дараах зүйлийг хэлж болно. Зоо болон фито социологи нь homo-социологийг илүүц гэж үзэхийн оронд харин ч бүр түүний оршин тогтнохыг шаардаж байна.

Үүнийг мөн арга зүйн эргэцүүлэл шаардаж байна. Шинжлэх ухаанд үзэгдлийн төсөөтэй талаас гадна ялгаатай тал нь ч чухал байдаг. Ялгаатай тал нь энд илт байгаа үед өөр хоорондоо төсөөгүй байгаа үзэгдлийн ангилалыг нэг бүлэгт нэгтгэх нь зүйд нийцэхгүй.¹⁸

Биологийн ерөнхий хэсгүүдийг аваад үзсэн ч тэр хүмүүсийн харилцааны үзэгдлийг судалдаг ухаан байхгүй, энд социологийг илүүц болгож байна. “Нийгэм бол организм”, тиймээс хүмүүсийн харилцаа нь амьд организмтай адил юм гэсэн социологи дахь “органик сургаалийн” утга санаа зөв бол дээрх зүйл бодитой орших байлаа. Гэвч бидний мэдэж байгаагаар “органик сургааль” эргэлт буцалтгүй мөхсөн. 1897 онд болсон социологийн олон улсын гуравдугаар их хурал дээр төгсгөлийн ялагдлаа хүлээсэн юм. Энд эл сургаалиа хамгаалж том төлөөлөгчид нь илтгэлээ тавьсан. Гэвч хамгаалалт амжилтгүй болж, хүмүүсийн харилцааг амьд организмын үйл явцтай адилтгах гэсэн бүх оролдлогод болон энэхүү сургаальд Их хурал яллах хатуу шийдвэр гаргасан билээ. “Органик сургаалийн тусламжтайгаар нийгмийн ухаанд ахиц дэвшил хийсэн ганц ч болов жишээ хэлээд өгөөч. Хүний янз бүрийн нийгмүүдийг харьцуулсныхаа тусламжтайгаар социологи нь хөгжин дэвшиж байгаа болохоос биш харин нийгмийг амьд организмтай харьцуулснаар ямар ч үр дүнд хүрээгүй” гэж Тард органик сургаалийг шүүмжлэн дүгнэн хэлсэн юм.¹⁹

Энэ бүгдээс дүгнэхэд *нэгдүгээрт, хүмүүсийн хоорондын харилцаа нь биологийн үйл явцад хамаарахгүй, хоёрдугаарт хамаарах болсон ч гэлээ энэ шинжилгээгээр sui generis-ийн үйл явц байхаа болихгүй, шинжилгээ нь хүнийг хүн биш, хүн бол нэг эст амьд юм гэж харуулж чадахгүй, гуравдугаарт энэ үзэгдлийг судлах нь онцгой шинжлэх ухааныг шаардаж байна, дөрөвдүгээрт биологи нь язгуур ухаан нь биш юм, тавдугаарт тэр нь социологи эсвэл homo-социологи байх ёстой.*

Биологийн баримт дээр тулгуурлан социологи нь өөрийн шинжлэх ухааныг бүрдүүлж болох ба тэгэх ч ёстой. Социологи нь судалдаг үзэгдэл үйл явцаа биологийн үндэслэлд харьцуулан тооцож болох боловч homo нийгмийн үзэгдлүүд болон зоо ба фито нийгэмлэгийн үзэгдлийн хооронд тэнцүүгийн тэмдэг тавих хүртэл харьцуулалт хийж болно гэж бодох нь алдаатай юм.

Социологи ба бие хүний сэтгэл судлал

Одоо нийгмийн ухаан болон оюун санааны шинжлэх ухаанд анхаарлаа хандуулж социологиос бие хүний болон хамт олны сэтгэл судлалд хандах хандлагын тухай асуулт гарч ирж байна. Хүмүүсийн хоорондын харилцаа нь мөн чанартаа юуны түрүүнд сэтгэл хөдлөл, үзэл санаа, дур хүслийн долгион болох сэтгэцийн харилцаагаар үүсдэг. Сэтгэл судлалын сургаальд багтдаг олонх социологичид хоёр гол дүгнэлт хийсэн байдаг. Нэгд, социологи нь сэтгэл судлалд тулгуурлах ёстой, хоёрт, социологи нь хамт олны сэтгэл судлалаас өөр зүйл биш юм.

Энэ үзлүүд үнэн үү? Юуны өмнө бие хүний сэтгэл судлалд хандая. Энэ нь хүмүүсийн хоорондын харилцааг судалдаг уу? гэсэн асуултыг өөрөөсөө асууя. Эсрэг хариулт өгөхөөс өөр аргагүй. *Социологи ба*

социологийг бий болгож чадахгүй”. “Нийгмийн харилцаа нь sociabilite байдлаараа амьтдад байхгүй, тиймээс амьтан ба хүний нийгмийн харилцааг харьцуулж судлах нь гарцаагүй үр дүнгүй билээ.” Мөн хүмүүсийн хоорондын харилцааны ертөнцийг одоохондоо экологийн ямар ч үзэгдэлд хамааруулахгүй байх нь хамгийн зөв нотолгоо гэж Лебагийн дэмжигчид болон бусад механикийн үзэлтнүүдийн шийдвэртэйгээр хэлж буй нь мөн чанартаа яг зөв юм.

¹⁸ Амьтан ба ургамлын ертөнцийн адил төстэй үзэгдэл хүмүүсийн хоорондын харилцааны баримтуудаас юугаараа ялгаатай вэ гэсэн энэ асуулт дээр удахаа болье. Учир нь цаашдаа энэ асуулттай дахин учрах болно. Ялгаа байгааг хүлээн зөвшөөрөх хангалттай зүйлүүд яригдсан гэж итгэж байна. Энэхүү ялгаанд эргэлзэж буй хүмүүс энэ хэсэгт урьдчилан итгэхийг хүсэж байна. Хангалттай нотолгоо доор дурьдагдах болно.

¹⁹ Tarde. La theorie organique des societies. Annales. T. IV. 237-238. Үүнтэй холбогдуулан органик сургааль болон түүний шүүмжтэй танилцахыг хүсч байна. Тэрбээр нэг талаас, органицистуудын социологийн салбарт хийсэн бүх үр дүнд (Лилиенфильд, Новиков, Вормсын илтгэлүүд), нөгөө талаас органицистуудын арга зүй, урсгалын ямар ч үр дүнгүй ажилд (Тард, Л.Штейн болон энэхүү сургаалийг шүүмжилсэн бусад шүүмжлэгчид) дүгнэлт хийж байна.

бие хүний сэтгэл судлалын судалгааны объект нь өөр юм. Сүүлийнх нь хүмүүсийн хоорондын харилцааг судалдаггүй, харин бие хүний сэтгэл, ухамсар, оюуны бүтэц, бүрэлдэхүүн, үйл явцыг судалдаг ухаан юм. Биологид нэг талаас биетүүдийн анатоми, морфологи, физиологи, нөгөө талаас зоо ба фито социологи болох экологийн хооронд оршдог харилцаа нь сэтгэл судлал ба социологийн хоорондох харилцаатай адил гэж өөрийн санааг тодорхой илэрхийллээ. Эхний шинжлэх ухаанууд нь биетүүдийн хоорондын харилцааг бус харин биетүүд доторх үзэгдлийг судалдагтай адил сэтгэл судлал нь хүмүүсийн хоорондын сэтгэцийн харилцааг бус харин бие хүний сэтгэхүй дэх үзэгдлийг судалдаг аж. Анатомитой адил сэтгэл судлал нь бие хүний сэтгэхүйг дур хүсэл, оюун ухаан, сэтгэл хөдлөл зэрэг хэсгүүдэд ялгаж задалдаг, мөн морфологитой адил сэтгэл зүйн зан байдал, авир, темперамент зэрэг сэтгэл зүйн хэв маягуудад ангилдаг боловч бие хүний оюун санаа, ухамсараас хальж судалдаггүй. Хүмүүсийн хоорондын сэтгэл зүйн харилцаа болох ярилцах, харилцан янз бүрийн үйлдэл үзүүлэх зэргийг сонирхдоггүй юм. Энэ нь түүний сонирхолын гадна оршдогтой адил морфологи, физиологи, морфологийн гадна талд зоо ба фито социологийн судалдаг экологийн үзэгдлүүд оршиж байдаг.

Энэ ялгааг тодорхой жишээ татаж ойлгомжтой болгоё. Нийгмийн баримтыг цэвэр сэтгэцтэй холбож эсвэл ганц сэтгэл судлалаар тайлбарлаж болохгүй гэж Dupreel хэлжээ. Жишээ нь: солиорол нь (la folio) сэтгэцийн болон биологийн баримт бөгөөд нийгмийн амьдралыг мөн сонирхдог. Сэтгэл судлаач солио өвчтэй хүний ухамсрын байдлыг судалж хэвийн байх үеийн ухамсарын байдалтай харьцуулдаг. Түүний үйлдлүүдийг судлах нь сэтгэцийн байдлыг харуулдаг үзүүлэлт болдогтой холбоотой учраас л сонирхдог байна. Биологич солио өвчтэй хүний эрхтнүүдийн байдлыг судалж, хам шинжүүдийн шалгуур болдогтой л холбоотой тул түүний үйлдлийг сонирхдог.

Социологийн үүднээс солио өвчтэй хүнийг судлаж эхлэхэд бүх зүйл өөрчлөгддөг. Социологичийн хувьд түүний сэтгэхүй болон бие дотор нь юу болж байгаа нь тийм чухал биш, энэ нь чухал асуулт биш юм. Түүнд нэг талаас, *нийгэм хүнийг солиотой гэж тооцож байгаа хам шинжийн мөн чанар, нөгөө талаас солиорлын үр дүн чухал байдаг*. Солиотой хүн ид солиорлын үедээ тавилга эвдсэн бол сэтгэл зүйчдэд хохирлын хэмжээ, сэтгэл зүйн байдал, үйлдэл тийм чухал биш. Солиотой хүний оюун ухааны байдал нь нийгэмд хамааралтай байдгийн адил социологичдоод мөн адил чухал. Социологийн үүднээс солиорол нь нийгэм, хүмүүс, ойр дотныхондоо хохирол үзүүлдэг тодорхой үйлдэл бүхий оюун ухааны тодорхой төлөв байдал гэж үздэг.²⁰

Сэтгэл судлал ба социологийн судалгааны объект хийгээд үзэл бодлын үндсэн ялгаа ийм байна.

Энэхүү ялгааг социологи дахь “сэтгэл судлалын сургаалийн” томоохон төлөөлөгчид хүлээн зөвшөөрөхгүй байж чадахгүй. “Ердийн сэтгэл судлал нь нийгмийн баримтуудын ээдрээг тайлах чадваргүй гэдэгтэй санал нийлж байна гэж Тард хэлжээ.”²¹

Үүнээс үүдэн тэрбээр харилцааны сэтгэл судлалыг бүтээхийг оролдсон ба энэ нь социологийн үндсэн хэсэг болох ёстой хэмээн үзэв. Үл тоох байдлаар ханддаг байсан “ердийн сэтгэл судлал” биш харин миний нэрлэсэнээр цаашдаа “харилцааны сэтгэл судлал” гэнэ. Харилцааны сэтгэл судлал эсвэл харилцааны логик нь мөн чанартаа энгийн социологи бөгөөд энэ нь нарийн төвөгтэй социологийг буюу гол утга бүхий социологийг тайлбарлаж чадна.²² Гол утга бүхий социологийн объектыг сэтгэл зүйн хоорондын харилцааны тодорхой төрөл гэж тэрбээр үзжээ. “Сэтгэл зүйн бүх харилцаа нийгмийн үзэгдэл болж чадахгүй” гэж тэрбээр хэлжээ. Нийгмийн үзэгдэл болохын тулд эдгээр харилцаа нь ганц “би”-гээс нөгөөд, бусдад нөлөөлж, эсвэл нөлөөллийг агуулж байж сая хүчин төгөлдөр болно.”²³

Үүнээс харахад харилцааны сэтгэл судлал буюу Тардын социологи нь “ердийн” буюу “бие хүний сэтгэл судлалын” шинжлэх ухаанаас ялгаатай. Тэдгээрийн объект, зорилт, агуулга, мөн чанар үлэмж ялгаатай байна.²⁴

Сэтгэл судлал ба социологийн (Тардын харилцааны социологи) судлах үзэгдлийн хүрээ үлэмж ялгаатай, тэднийг хольж хутгах эсвэл адилтгах бага боловч үндэслэл байхгүй гэдгийг хүлээн

²⁰ Dupreel. Sociologie et psychologie. Institut Solvay. Bulletin mensuel. Янв. 1911. 180- 6. Мөн Зиммель хар. Социологийн асуудал. Социологи дахь шинэ санаа. Эмхтгэл. №1. 136-141.

²¹ Тард. Сэтгэл судлал ба социологи. Социологи дахь шинэ санаа. Эмхтгэл. №2. СПб., 1914. 70.

²² Тард. Мөн тэнд. 69-78.

²³ Тард. Сэтгэл зүйн нөлөөллийн онол. Парис дахь нийгмийн ухааны оросын дээд сургууль. СПб., 1905. 5.

²⁴ Социологи, харилцааны сэтгэл судлалыг зоо болон фито социологитой адилтгасныг Тард зөв ойлгожээ. Тэрбээр “өөрийн санааг илүү ойлгомжтой илэрхийлэхийн тулд миний ярьж буй шинжлэх ухааныг харилцааны физиологи эсвэл харилцааны биологитой жишиж үзэхэд илүүдэхгүй байх гэжээ. Биологий энэхүү салбар бий гэж хэлж болох юм. Амьдралын төлөө тэмцэл гэх Дарвины зарчмын дагуух төрөл зүйлийн үүсэл нь харилцааны физиологийн өргөн хүрээтэй, тасралтгүй үйл явцаас өөр зүйл биш. (физиологи доторх гэж зарим гүн сэтгэгч байгалийн шинжээчид үздэг нь буруу). Бичил биетэн (нян) ба түүний том организмтай харилцах харилцааг судлах нь харилцааны физиологийн өргөн хүрээтэй, баялаг ирээдүйтэй салбар болохыг илтгэж байна.” Сэтгэл зүйн нөлөөллийн онол. 10.

зөвшөөрөхүйц хангалттай ярьсан. Нэг нэгэн дээр нь давхцуулсан ч нийцэхгүй, харилцан нөхөж чадахгүй.²⁵

Социологи ба хамт олны сэтгэл судлал

Социологийн хамт олны сэтгэл судлал эсвэл нийгмийн сэтгэл судлал, өөрөөр хэлбэл ард түмний сэтгэл судлалд (*Volker psychologie*) хандах хандлагын хувьд асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ ойлголтын дор юуг ойлгож байгааг авч үзэх ёстой. Энэхүү нэрийн дор юуг ойлгож байгааг судлаад үзэхэд объект нь хэсэгчлэн таарч байгааг хэлэх хэрэгтэй. *Сигелегийн* үзлээр хамт олны сэтгэл судлал нь хүмүүсийн хоорондын харилцааны үзэгдлийг судалдаг бөгөөд судалгааны нэгж нь сул органик харилцаа холбоо бүхий янз бүрийн бие хүмүүс болдог. (Бөөн хүмүүс, үзвэр үзэгчид, хурал, тохиолдлын хурал г.м). Ийм бүлгүүдэд нэг төрлийн, органик нэгдэл бүхий төхөөрөмжөөс өөр харилцааны төрлүүд бий болдог. Энэ байдал Сигелегийнхээр социологиос ялгаатай хамт олны сэтгэл судлал бүрэлдэх үндэс болдог байна. Түүнийхээр социологи нь “нэг төрлийн”, “органик нэгдэл” бүхий нэгжүүдийн хоорондын харилцааг судалдаг байна.²⁶

Де ля Грессеригийн үзэл бодол мөн л ийм байсан бөгөөд түүний үзлээр хамт олны сэтгэл судлалын объект нь тохиолдлын, зохион байгуулалтгүй, ялгаралгүй, тогтворгүй харилцааны цогцолбор болдог. Зохион байгуулалттай цогцолбор нь нийгмийн сэтгэл судлалын объект болдог.²⁷

Г.Лебон үзлээр хамт олны сэтгэл судлал нь арьстнуудын сэтгэл санааг судалдаг шинжлэх ухаан юм.²⁸ Ихэнх италичууд хамт олны сэтгэл судлал болон социологиос гадна нийгмийн сэтгэл судлалыг ялгаж авч үздэг. *Россигийн* үзлээр хамт олны сэтгэл судлал нь нэгдэл дээр тулгуурлан гарч ирсэн тохиолдлын нийлбэр (бөөн хүмүүс)-ийн харилцааг судалдаг. Нийгмийн сэтгэл судлал нь “ард түмний болон арьстны сэтгэл санааг” өөрөөр хэлбэл тогтвортой цогцолборын сэтгэл санааг судалдаг бол социологи нь аль аль шинжлэх ухааны титэм нь болж, анхандаа ухамсаргүйн түвшний автомат үйлдэл, дараа нь улам бүр ухамсартай нийгмийн үйлдэл судалгааны объект нь болдог.²⁹

Ф.Сквиллаче, Кольмо, Гроциали нар мөн төсөөтэй үзэл бодолтой байна. Бидний мэдэж байгаагаар Тард хамт олны сэтгэл судлалын оронд социологитой адилтган харилцааны сэтгэл судлалыг бүтээж байгаа юм.³⁰

²⁵ “Социологи” ба “сэтгэл судлалын” сургаалийн тэмцэлтэй холбоотой социологи ба сэтгэл судлалын харилцааны тухай асуудлаар маргахдаа ямар ч үндэслэлгүй хурцадсан. Хэрэгт шууд хамааралгүй, ихэвчлэн арга зүйн шинжтэй олон асуудлаар маргалдаж байв. Жишээ нь: Контын шинжлэх ухааны ангилалд социологи болон сэтгэл судлалын эзлэх байр суурийн тухай, бие хүний сэтгэл судлалын шинж чанаруудаар нийгмийн үйл явцыг тайлбарлах шаардлагатай эсэх, эсвэл бие хүн, нийгэм нь бодит байдал учраас бие хүний сэтгэл зүйг үйл явцын үүргийн тайлбарлах г.м асуудлууд байна. Эдгээр маргаан нь ихэвчлэн эргэлзээтэй, шууд хамааралгүй асуудлаар болж байсан бөгөөд “социологийн” бусад салбаруудыг доор ярих явцад хөндөгдөх болно. Энд социологи болон сэтгэл судлалын хоорондын ялгааг авч үзсэн нь хангалттай.

Эдгээр маргааныг дараахаас хар: Сорокин. Социологийн судлах зүйл ба хил хязгаар. Социологи дахь шинэ санаа. Эмхтгэл. №1. 102-108., Эмхтгэл. №2. Энэ асуудалд тусгайлан зориулсан эмхтгэл “Социологи болон сэтгэл судлал” (Де Роберти, Дюркгейм, Тард, Колле, Драгиченко, Палантын өгүүлүүд). Мөн дараахыг хар: Baldwin. Psychologie et sociologie (l'individu et la societe). Олон улсын социологийн бүтээлийн хэвлэлийн газар. Уорд, Дюркгейм, Кост, Леви-Брюль, Бугле болон бусдын бүтээл.

²⁶ Сигеле. Гэмт бөөн хүмүүс. СПб., 1896. 3-17.

²⁷ Де ля Грессери. De la psychosociologie. Revue de sociologie. 1912. №3. 163.

²⁸ Лебон. Ард түмний хувьслын сэтгэл зүйн хууль. СПб., 1906. “Арьстны сэтгэл санаа”.

²⁹ P.Rossi. Psicologia collettiva. Milano. 1900. 213. Sociologia e psicologia collettiva. 99-112, 145-149.

³⁰ Тард. Сэтгэл зүйн нөлөөллийн онол. “Нийгмийн буюу хамт олны сэтгэл судлал гэсэн ухагдахуун миний санаанд хүрэхгүй байна. Энэ нь төөрөгдөлд хүргэж болох бөгөөд үүгээр далимдуулан тэдгээр ухаантнууд нь нийгмийн тухай ойлголтыг бидний хувь хүний ухамсраас ялгаатай өвөрмөц нийгмийн “би” бүхий бидний жижиг тархинуудаас бүрдсэн асар том тархитай зүйрлэн далдлахыг эрмэлзэж байна. Үүнээс гадна энэхүү ойлголт нь бүрхэг ойлгомжгүй байгаа бөгөөд олон янзын ангилалын зөвхөн нэгэнд хамааралтай байна. Тиймээс би хамт олны эсвэл нийгмийн сэтгэл судлалын тухай бус харин илүү ерөнхий, илүү тодорхой өөр шинжлэх ухааны тухай буюу миний нэрлэж байгаагаар харилцааны сэтгэл судлалын тухай ярих хэрэгтэй санагдаж байна. 3-5.

Хамт олны (нийгмийн) сэтгэл судлалын талаарх энэхүү товчхон тоймоос харахад нэгдүгээрт, хэрэв энэ нь хүмүүсийн хоорондын харилцааны явцад үүсэж буй харилцааны үндсэн хэв маягуудыг судлахыг зорилгоо болгосон бол, өөрөөр хэлбэл дээр яригдсан социологийн судалдаг зүйлтэй адил бол социологитой нийлж хоёр нэрний нэг нь илүүц болно. Аль нэр гэдэг нь хамаагүй, нэрэнд гол учир оршдоггүй, харин шинжлэх ухааны шинж чанар хамаг учир оршиж байгаа юм. Энэ тохиолдолд би социологи гэдэг нэрийг эрхэмд үзэж байна. Хоёрдугаарт, хэрэв хамт олны (нийгмийн) сэтгэл судлалын доор Сигеле, Грессери, Тард, Росси, Сквиллаче нарын бодож байсанчлан ойлговол энэ нь ердөө хүмүүсийн хоорондын харилцааны бүх хэв маягийг судалдаг хэмээн социологийн орой дээр гарч ирнэ.

Ийнхүү социологи ба хамт олны сэтгэл судлалын, тэрчлэн нийгмийн ба харилцааны сэтгэл судлалын хоорондын харилцааны тухай асуудал шийдвэрлэгдэж байна.

Социологи ба хүмүүсийн харилцааг судалдаг тусгай шинжлэх ухаанууд

Одоо социологийн судалдаг үзэгдлүүдийг шинжилдэг бусад нийгмийн шинжлэх ухаанууд болон социологийн харилцааг авч үзэх л үлдлээ. Улс төр эдийн засгийн, эрх зүйн, шашны, урлаг судлалын шинжлэх ухаанууд болон бусад “нийгмийн” ухаанууд нь бүгд хүмүүсийн хоорондын харилцааг судалдаг. Эрх зүйн гол ойлголтууд нь нийгмийн харилцаанд хөтөлж буй ойлголтууд юм гэж Dupreel маш зөв тэмдэглэжээ. Хариуцагч ба өртөн, эзэн ба боол, нөхөр ба эхнэр хоорондын харилцаа нь хүмүүс хоорондын харилцааны ердийн хэлбэрүүд юм. “Өмчийн харилцаа нь эзэн эд юмсдаа хандаж буй энгийн харилцаа бус харин өмчтөн нийгмийн бусад гишүүдтэй харилцах харилцаа болдог.” Үүнийг мөн захиргааны, төрийн, эрүүгийн г.м эрхийн судалдаг үзэгдэл үйл явцад хамааруулж болно. “Ямар ч эрхийн харилцаа нь онцгой үзэл бодлын үүднээс авч үзэж буй нийгмийн харилцаа юм”³¹ Хүмүүсийн хоорондын үйлдэл, эс үйлдэл, тэвчээр, харилцан үйлдэл, хариу үйлдэл зэрэг нь эрх зүйн судалгааны объект болдог гэж Л.И. Петражицкий тодорхой харуулжээ.³² Товчхондоо, эрх зүйн шинжлэх ухаан нь хүмүүсийн хоорондын харилцааны өвөрмөц хэлбэрийг судалдаг юм.

Үүнтэй мөн ижил зүйлийг улс төр эдийн засгийн ухааны тухай хэлж болох юм. Улс төр эдийн засгийн ухааны судлах зүйл бол хүмүүсийн аж ахуйгаа хамтран хөтлөх үйл ажиллагаа,³³ өөрөөр хэлбэл материаллаг баялгийн үйлдвэрлэл, солилцоо, хуваарилалт, хэрэглээний хүрээн дэх хүмүүсийн харилцааны тодорхой хэлбэр юм. Эрэлт хэрэгцээнээс үүдэлтэй хийгээд үнэт зүйл дээр тулгуурлан гарч ирэх харилцаа нь нийгмийн харилцаа буюу хүмүүсийн хоорондын харилцааны тодорхой төрлүүд хэмээн Дюпреел зөв зүйтэй тэмдэглэсэн.³⁴

Ёс суртахуун буюу ёс зүйн, шашны, урлагийн тухай нийгмийн бусад шинжлэх ухааны талаар мөн адил зүйлийг ярьж болох юм. Ёс суртахууны тухай шинжлэх ухаан нь хүмүүсийн үйлдэл, ухамсрын хамтын хэлбэрүүдийг судалдаг. Ёс суртахуун бол хүний зан үйлдлийн тодорхой хэлбэр бөгөөд хамтын зан үйлийн журмыг зааж өгдөг. Гоо зүй нь зохиолч ба уншигч, жүжигчин ба үзэгч, зураач ба хүмүүс, төгөлдөр хуурч ба сонсогч хоорондын харилцаа, солилцоон дээр тулгуурлан үүссэн харилцааг судална. Шашны тухай шинжлэх ухаан нь сүсэг бишрэл, үзэл санаагаараа нэгдэж сүм хийд хэмээх хамтын нийтлэг бүхий сүсэгтнүүдийн хоорондын харилцааг судалдаг.³⁵

Ерөнхийдөө нийгмийн ухаанууд нь хүмүүсийн хоорондын харилцааны олон янз төрлийг судалдаг.

Социологи болон нийгмийн ухаануудын судалгааны объект нь бүхлээрээ биш юм гэхэд зарим талаараа давхцаж байгаа тохиолдолд социологи эдгээртэй ямар харилцаанд байна вэ? Нийгмийн бүх ухаануудын цогц нийлбэрийг илэрхийлсэн энгийн шошго болж байна уу? эсвэл нийгмийн шинжлэх ухааны мэдлэгийн аль ч салбартай үл нийцэн бие дааж орших боломжтой юу? гэсэн асуулууд гарна.

Энэ асуудлаар социологийн бүтээлүүд дэх үзэл санааг авч үзвэл 2-3 үндсэн бүлэгт хувааж болохоор байна. 1) социологийг *бүх нийгмийн ухааны corpus* гэж үздэг үзэл (нийгмийн үзэгдлийг судалдаг бүх тусгаар ухаануудын нийлбэрийг илэрхийлсэн энгийн ухагдахуун гэж социологийг үздэг); 2) *бусад шинжлэх ухаануудын судалдаггүй* нийгмийн асуудлын тодорхой төрлийг социологийн судалгааны объект хэмээн үздэг үзэл; 3) социологи нь хүмүүсийн хоорондын харилцааны *ерөнхий энгийн шинжүүдийг* судалдаг бие даасан шинжлэх ухаан хэмээн хүлээн зөвшөөрсөн үзэл.

³¹ E.Dupreel. La rapport social. (Essai sur l' objet de la method de la sociologie). Paris, 1912. IV бүлэг. 48-113.

³² Петражицкий. Эрх зүйн онол. I ба II боть.

³³ Улс төр эдийн засгийн ухааны бүтээлийг хар: Туган-Барановский, Чупров, Железнов, Мануйлов, Каблуков нар. Ялангуяа Д.М.Орженикий хар. Эдийн засгийн үзэгдлийн тухай ойлголт. 1903.

³⁴ E.Dupreel-ийг илүү тодорхой хар. Иш татсан номын 56-70 тал.

³⁵ E.Dupreel-ийг илүү тодорхой хар. Мөн тэнд 70-113.

Эдгээр үзлийг нэг бүрчлэн авч үзье. *Дюркхайм* ба түүний хамтран зүтгэгч *Фоконнегийн* эхэн үеийн үзэл бодол нэг дэх үзлийн жишээ болж байна. “Социологи нийгмийн ухаануудын зөвхөн *corpus* болдог гэж ярьдаг”³⁶

Зиммель, Бугле, Гумплович нарын үзэл бодол хоёр дахь үзлийн жишээ болж байна.

М.М.Ковалевский, Де-Роберти, Де-Греф, Уорд, Морселли, Элвуд, Кареев, Дюркхайм (хожуу үеийн үзэл), *Воррис* нарын ихэнх социологичдын үзэл гурав дахь үзлийн жишээ болж байна.

Эдгээр үзэл бодолд анхаарлаа хандуулъя. Нэг дэх үзлийн сэдэл нь ийм юм. Дюркхейм, Фоконне нарын үзлээр нийгмийн ертөнц нь хязгааргүй учраас нэгмөсөн бүхлээр нь авч үзэх оролдлого хийсэн ч түүний тухай нэг мөр, эргэлзээгүй ойлголттой болж чадахгүй юм. Тиймээс ингэхийн тулд нийгэмтэй эртнээс ерөнхийд нь танилцаж, хамгийн энгийн бүрхэг мэдлэгтээ сэтгэл хангалуун байх хэрэгтэй. Иймээс нийгмийн хэсэг болгоныг тусгайлан судлах шаардлагатай бөгөөд хэсэг болгон нь бүхэл бүтэн шинжлэх ухааны судлах зүйл болох хангалттай өргөн талбар юм.³⁷

Эдгээр сэдэл нь зөв юм. Үзэгдлийг нарийн танин мэдэх зорилгоор шинжлэх ухаануудад хөдөлмөрийн хуваарь байх нь зайлшгүй бөгөөд чухал юм. Үүнээс үүдэн зохиогчдын хэлж байсан дүгнэлт хэрэггүй аж. Шинжлэх ухааны нарийсал болон ялгарал нь шинжилгээний үндсэн үр дүнг нэгтгэн дүгнэх нийлмэл шинжлэх ухааныг үгүйсгээгүй харин ч бүр оршин байхыг шаардаж байна. Хоёрдугаарт, хэрэв социологи нь нийгмийн ухаануудын зөвхөн энгийн *corpus* байвал энэ нь *хоосон үг* болон хувирч, гэнэн хүмүүсийг төөрөгдүүлэх шошго төдий зүйл болно. Өөрийн агуулгагүй шошго нь ямар ч хэрэггүй юм. “Үүний үр дүнд агуулга ба харилцааг илэрхийлсэн шинэ нэр үүсгэх эсвэл судалгааны хуучин салбарын хүрээнд бүрэлдэн бий болно.”³⁸

Үүнээс харахад нэг дэх үзлийг үгүйсгэхэд хүрч байна.

Хоёрдох үзэлд хандая. Энэ нь социологийг нийгмийн үзэгдлийг судалдаг бусад нийгмийн ухаануудтай холилдоогүй бие даасан шинжлэх ухаан гэж хүлээн зөвшөөрснөөрөө гуравдах үзэлтэй төстэй. Дээр дурьдсан хоёрдох шийдвэр нь объектын өвөрмөц шинж дээр тулгуурлан социологийн бие даасан байдлыг үндэслэдгээрээ хоёр үзлийн хоорондын ялгаатай талыг илтгэнэ. Үүний объект нь бусад нийгмийн шинжлэх ухаан судалдаггүй үзэгдлүүд байх ёстой. Социологид судалгааны өөрийн булан байх нь зүйтэй. Социологийн объектын энэхүү өвөрмөц шинж нь бусад нийгмийн шинжлэх ухаанаас ялгаатай, түүнийг бие даасан тусгай шинжлэх ухаан болгож байна. Гуравдах үзэл хоёрдахийг бодвол социологийн бие даасан байдлыг бусад шинжлэх ухаануудын оролдоогүй, хөндөөгүй “хэлтэрхийг” шинжлэх ёсгүй гэдэг дээр үндэслэдэг. Тиймээс ч хүмүүсийн хоорондын харилцааны тодорхой талуудыг судалдаг тусгай шинжлэх ухаанууд оршин байдаг. Хүмүүсийн хоорондын харилцааны нийтлэг үзэгдлийг судалдаг шинжлэх ухаан хамгийн чухал юм. Түүний объект нь мөн л үзэгдлүүд болох бөгөөд зарим хэсгийг тусгай шинжлэх ухаанууд судалдаг гэвч өөр бас үзэл бодол байна. Социологи нь түүнийг бүхэлд нь даяар авч үзэхийн хамт нийгмийн үзэгдлүүдийн бүх төрлүүдэд нийтлэг, ерөнхий байгаа зүйлд анхаарлаа төвлөрүүлдэг. Харьцуулан үзье. Үйлдвэрт ажилчин болгон өөрийн ажлаа хийж тодорхой үүргийг гүйцэтгэж байдаг. Гэвч энэ хөдөлмөрийн хуваарьт дарга удирдлагын ажил ямар ч хэрэггүй юм. Тэдгээр нь байгууллагыг удирдаж, ажлын болон ээлжийн ерөнхий төлөвлөгөөг тогтоож, бүх ажилчин мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг ажиглан зохицуулж байдаг. Товчхондоо үйлдвэрийг бүхэлд нь захирч, нэгдмэл системтэй үйл ажиллагааг шаарддаг. Түүнгүйгээр бүх ажил гажиж, үйлдвэр нурна. Үүнийг мөн социологи ба тусгаар нийгмийн ухаануудын харилцаанд ашиглаж болох юм. Мэргэжилтний үүргийг энд тусгаар нийгмийн шинжлэх ухаанууд, дарга удирдлагын үүргийг социологи гүйцэтгэж байна. Социологийн ийм бие даасан байдал яригдаж буй нь гуравдах үзэл бодолд хамаарна.

Нэгбүрчлэн авч үзье. Хоёрдах шийдвэрийн жишээгээр *Зиммелийн* онолыг авч үзье. Түүний үзлээр социологийн объект бол харилцааны *хэлбэрүүд* юм. “Нийгмийн үзэгдлийн бүхий л материйг бусад нийгмийн ухаанууд аль эрт эзлээд судалж байна гэж тэрбээр бичжээ. Энд социологийн хийх ажил байхгүй. Хэрэв тэр бие даан оршихыг хүсвэл судалгааны өөрийн “хэлтэрхийтэй” байх хэрэгтэй. Цорын ганц ийм “хэлтэрхий” бол бусад шинжлэх ухаануудын оролдоогүй харилцааны агуулга ба материас хамааралгүй “*харилцааны хэлбэрүүд*” юм. Нэг ижил геометрийн дүрсүүдийг тухайлбал, бөмбөлөгүүдийг олон янзын агуулгаар дүүргэж болох ба мөн эсрэгээр нэг агуулгыг (матери) олон янзын геометрийн

³⁶ Durkheim. Sociologie et sciences sociales. Revue philisophique. Би Дюркхаймийн эхэн үеийн үзэл бодлыг бичиж байна. Учир нь тэрбээр энэ асуудлаар хожим үзлээ өөрчилсөн байна. “Шинжлэх ухаан дахь арга” хэмээх эмхтгэлдээ хэвлүүлсэн ижил нэртэй өөр нэгэн өгүүлэлдээ “in abstracto” гэж нийгмийн баримтыг тодорхойлсон нийгмийн суурь шинжүүдийг судалдаг “ерөнхий социологи” оршин байхыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Шинжлэх ухаан дахь арга. 233. Хожим тэрбээр энэ асуудлаар улам эрс дуугарч, өөрийнх нь үзлийг гажуудуулж буй Ришарыг буруутган “Ришарын хэлж буй Дюркхаймийн ерөнхий социологи байх боломжгүй гэдэг нь буруу юм. Ерөнхий социологи байх боломжийг би үгүйсгээгүй, үгүйсгэхгүй” хэмээн Дюркхайм бичжээ.

³⁷ Дюркхейм, Фоконне. Revue philis. 474.

³⁸ Зиммель. Социологийн асуудал. Социологи дахь шинэ санаа. Эмхт. №1. 111

дүрсүүдэд багтааж болно. Хүмүүсийн харилцааны хэлбэрүүд нь зарим тохиолдолд нэг агуулгатай байдаг бол зарим үед өөр агуулгатай болдог. “Зорилго чиглэлээрээ ямар ч адилгүй нийгмийн бүлгүүдэд бие хүмүүсийн хоорондын харилцааны ижил хэлбэрийг олж болно. Төрийн байгууллагад, шашны нийтлэгт, хуйвалдагчдын бүлэглэлд, эдийн засгийн нөхөрлөлд, уран сайхны сургуульд болон гэр бүлд манлайлал, захирагдалт, өрсөлдөөн, дууриалт, хөдөлмөрийн хуваарь, намуудын үүсэл, төлөөлөл, дотооддоо хумигдах, гадаадаа явцуурах зэрэг тоо томшгүй нийгмийн үзэгдлүүдтэй тулгарна. Нийтлэгт хүргэж буй хүсэл сонирхол хичнээн олон янз байсан ч үйлдэгдэж буй хэлбэр нь ижил байж болно. Нөгөө талаас, агуулгын хувьд ижил хүсэл сонирхол нь олон янз нийтлэгээр илэрхийлэгдэж болно. Тухайлбал, эдийн засгийн сонирхол нь өрсөлдөөний замаар болон үйлдвэрлэгчдийн төлөвлөгөөтэй зохион байгуулалтын замаар хэрэгжиж болно; сүсэгтний амьдралын агуулга нь заримдаа эрх чөлөөтэй, заримдаа төвлөрөн аж төрөх хэлбэрийг сонгохыг шаардаж байна; хүйсүүдийн харилцааны сонирхол нь гэр бүлийн тоолшгүй олон янз хэлбэрийг бий болгоход хүргэдэг г.м.³⁹

“Социологи нь хүн төрөлхтний нийгмийн ахуйн тухай сургааль бөгөөд геометр нь материйн тухай физик-химийн ухаанд хандахтай адил бусад тусгай шинжлэх ухаанд судлах объект байж болох талтай.”⁴⁰

Зиммелийн үзэл бодлын мөн чанар ийм байна. Түүнтэй Булгегийн байр суурь төстөй.⁴¹

Социологийг онцгой объекттой гэж үздэг байр суурьтай бусад социологичид арай өөр шинжийг гаргаж ирсэн. “Социологийн объектыг хүмүүсийн бүлгийн хөдөлгөөн ба нэг нэгэндээ нөлөөлөх харилцан нөлөөлөл гэж Гумплович үзжээ.”⁴²

Социологи ба бусад нийгмийн ухаануудын харилцааны тухай асуудлыг ингэж шийдвэрлэж болох уу? гэсэн асуулт гарч ирж байна.

Тийм, мөн үгүй. Зиммелийн нэрлэсэн үзэгдэл гэх “харилцааны хэлбэр” нь хүмүүсийн харилцааны олон янзын агуулга бүхий үзэгдлүүдийн шинж чанарын цогцолборыг хамарч байдаг учраас түүний байр суурь зохистой. Энэ тохиолдолд түүний байр суурь гуравдах үзэлд хамаарна. Харилцааны хэлбэр гэдэгт бусад шинжлэх ухааны судалдаггүй sui generis-ийн үзэгдлийг ойлгодог ба бусад нийгмийн шинжлэх ухааны нэгэн адил социологийг тусгай шинжлэх ухаан болгодог. Энэ тохиолдолд социологи нь Риккертийн хэлснээр “удирдах”, Виндельмандийн томъёолсноор хийсвэр шинжлэх ухаан биш, харин хүмүүсийн харилцааны “хэсэгхэн хэлтэрхийг” судалдаг тусгай шинжлэх ухаан гэж үздэг учраас Зиммелийн үзэл бодлыг үгүйсгэх шаардлагатай болов. “Харилцааны хэлбэрүүд” нь үнэхээр харилцааны агуулга, материас ялгаатай ямар нэгэн зүйл юм гэсэн Зиммелийн үзлийг зөвтгөе гэж бодье. “Харилцааны хэлбэрийг” судлахын тулд тусгай шинжлэх ухаан бүтээе гэж бодье. Үүнээс ямар үр дагавар гарах вэ? Тэгвэл одоогийн байгаа нийгмийн шинжлэх ухаан дээр дахин нэгэн тусгай шинжлэх ухаан нэмэгдэнэ. Гэхдээ нийгмийн үзэгдлийн ерөнхий шинж чанарын тухай “удирдах” шинжлэх ухаан байх хэрэггүй гэж үзэж болохгүй. Мөн энэ нэмэлт тусгай шинжлэх ухаан нь “удирдах” шинжлэх ухааны үүрэг гүйцэтгэх эсвэл түүний оронд очих боломжтой гэж үзэж болохгүй. Ийм мэдлэгийн нэмэлт салбар бий болсноор үйлдвэрт нэмэлт ажилчин мэргэжилтэнг олшруулах боловч байгууллагын дарга удирдлагын хэрэгцээг хангаж чадахгүй. Чиглүүлэх, ерөнхийлөх үүрэг бүхий удирдлагагүйгээр байгууллага оршин тогтнож чадахгүй. Хүмүүсийн хоорондын харилцааг судалдаг тусгаар шинжлэх ухаанууд нь “удирдах” шинжлэх ухаангүй оршин байх боломжгүй. Тиймээс Зиммелийн энэ “социологи” нь тусгай шинжлэх ухаан болохынхоо хувьд хүмүүсийн хоорондын харилцааны энгийн шинж чанарын тухай “удирдах” шинжлэх ухааныг үгүйсгээгүй, мөн үгүйсгэхгүй байх байсан.

Зиммель сайндаа л өөрийн оролдлогоор зөвхөн социологи хэмээх нэмэлт тусгаар шинжлэх ухааныг л бүтээх байсан.

Гэхдээ герман социологичдын бүтээлийн тухай ингэж баттай хэлж чадахгүй. Зиммелийн бүтээлийн хуурмаг үзэл нь түүний томъёоллын зүйрлэл зүй дээр ялангуяа германчуудын дуртай “хэлбэр” ба “матери”-ийн эсрэгцэл дээр суурилж байдаг. Эдгээр ухагдахуунууд нь хүмүүсийн хоорондын харилцааг илэрхийлсэн ойлголтон дээр биш харин уран сайхны үзэгдлийн салбарт илүүтэй хамааралтай. Эдгээр “харагдахуйц” ойлголтыг шинжлэхэд “будаж шунхадсан зүйлийн” доор хуучин танил зүйл агуулагдаж байдаг. “Хэлбэр” нь энгийн суурь шинжтэй илүү өргөн ойлголт болж, харин “матери” нь хэлбэрээс хамааралтай ойлголт болж хувирсан байна. Ийнхүү “эрэгтэй” хэмээх ойлголтын хувьд “хүн” гэдэг нь “хэлбэр” болдог бол “хүн” хэмээх ойлголтын хувьд “эрэгтэй” гэдэг нь “матери” болж байдаг. “Хэлбэр” ба “матери”-ийг өөр зүйл мэтээр сөргөлдүүлэн үзэх нь зөв юм уу гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

³⁹ Simmel. Sociologie. 1908. 8-9.

⁴⁰ Мөн тэнд. 12.

⁴¹ Bougle. Les sciences sociales en All-magne. Paris. Alcan. 160.

⁴² Гумплович. Un programme de sociologie. Annales. I. 76, 104. Социологи ба улс төр. I. 895. Социологийн үндэс. СПб., 1899. 112.

Штаммлер эдгээр ойлголтоор таатай нь аргагүй тоглож үнэлэлт дүгнэлт өгөхдөө дээрх үр дүнд хүрч өөрийн бүтээсэн “шинэлэг” талыг устгахад хүрсэн байна.⁴³

Зиммель “хэлбэр” ба “матери”-ийг сөргөлдүүлэн үзсэн тухай мөн адил зүйл ярих хэрэгтэй байна. Түүний бүтээл энэ утгаараа зарчмын хувьд ямар ч хэрэггүй, эсвэл Зиммелийн “хэлбэр” гол ойлголт, харин “матери” нь дагалдах ойлголт гэдэгт хүргэнэ. Геометрийн дүрсүүдтэй адилтгах нь үндэслэлгүй учраас зарчмын хувьд ямар ч хэрэггүй юм. Геометр нь орон зайд асуудлыг авч үздэг учраас хэлбэрийн тухай ярих ёстой. Түүний объект нь мөн чанартаа “харагдахуйц” байдаг. Бодит байдал дээр хүмүүсийн харилцаа, юмсын байрлал маш өөр байдаг. Эрх мэдэл, захирагдалт, хөдөлмөрийн хуваарь, өрсөлдөөн нь харагдахуйц орон зайн байрлалыг эзэлсэн байдаг юм уу? Тэдгээр нь гурвалжин эсвэл дугуй хэлбэртэй байдаг уу? Өргөн эсвэл нарийн байдаг уу? Хавтгай эсвэл гүдгэр байдаг уу? Эдгээр ухагдахуунд нь ялгарал, эв нэгдэл г.м ойлголтонд яавч таарахгүй. Хэрэв харьцуулалт хийж байвал ямар нэгэн төсөөтэй зүйл байх ёстой биз дээ! Энд ямар ч тийм зүйл алга, тиймээс тухайлбал, бөмбөлөг гэх мэтгэй харьцуулах нь энгийн зүйрлэл, асуудлын мөн чанарыг тайлахгүй бүрхэгдүүлдэг.

Харилцааны адил хэлбэрүүд өөр өөр агуулгатай, мөн үүний эсрэгээр адил агуулгатай харилцаа өөр өөр хэлбэртэй байж болох тухай үзэл бодол алдаатай юм. Энэхүү алдааны нотолгоог Зиммель өөрөө “Социологи” номынхоо турш гаргасан байна.

Бидний өмнө захирах, захирагдах “харилцааны хэлбэр” харагдаж байна. Энэ нь дарангуйллын болон бүгд найрамдах улсад, мөн бүлгийг хэмжээлшгүй эрхт ганц хаан захирах эсвэл иргэдийг хоёр буюу ардын олон төлөөлөгчид захирах нь хоорондоо адил уу? гэсэн асуулт гарч ирж байна. Энэ асуултанд түүх маш ойлгомжтой хариулсан, эсрэгээр хариулсан. Зиммель мөн өөрөө ингэж хариулсан. Нэг хүн бүлгийг захирах нь хоёр хүн бүлгийг захирахаас үлэмж өөр “хэлбэртэй” байдаг. Захирагч захирагдагчийн хоорондын харилцаа, түүний мөн чанар, үүрэг нь энэ тохиолдолд маш их ялгаатай байдаг.⁴⁴

Өөр өөр агуулгатай “харилцааны хэлбэрүүдийг” хоосон адилтгаж байгаагаас “захирах” гэдэг үг, мөн захирагч захирагдагчийн хоорондын харилцааны ерөнхий суурь шинжүүд л үлджээ. Зиммелийн судалсан бусад “харилцааны хэлбэрүүдийн” шинжилгээнээс харж болно.⁴⁵

Харилцааны адил хэлбэрүүд өөр өөр агуулгатай, мөн үүний эсрэгээр адил агуулгатай харилцаа өөр өөр хэлбэртэй байж болох тухай түүний энэхүү үзэл нэг бол үндсээрээ худлаа, эсвэл сайндаа л дараах байдлаар ойлгож болно. Суурь үзэгдэл нь (жишээ нь захирах) төрлүүдэд хуваагдаж болно. Суурь үзэгдэл буюу суурь ойлголтыг болзмол байдлаар хэлбэр, төрлийг нь матери гэж нэрлэдэг. *Зиммелийн ийм үзэл нь дээр дурьдсанчлан гуравдах үзэлд хамаарна.* Социологи нь хүмүүсийн харилцааны үзэгдэл болгонд хамаарах ерөнхий суурь харилцаануудын хэлбэрийн тухай шинжлэх ухаан юм.

Байдал ийм л байна. *Социологийн судалдаг “харилцааны хэлбэрийг” бусад нийгмийн шинжлэх ухаанууд судалдаггүй, мөн “матери” нь болдоггүй гэж Зиммель үзсэнээрээ том алдаж байгаа юм.* Захирах ба захирагдах үзэгдэл нь төр эрх зүйн ухааны судлах зүйл болдоггүй гэж үү? Эрх мэдэл, төр, эрх мэдлийн харилцаа, захирах хэлбэр, төрөл г.м нь төр эрх зүйн ухааны тусгаар бүлгүүд болдоггүй гэж үү.⁴⁶

Die Treue ба Dankbarkeit нарын нэрлэсэн “харилцааны хэлбэр” нь зарим нийгмийн шинжлэх ухаанд “матери” нэрэн доор судлагддаг (тухайлбал, солилцоо, эрэлт, хэрэгцээг улс төр эдийн засгийн ухаан судалдаг; эв нэгдэл, хөдөлмөрийн хуваарийг ёс зүй, төр эрх зүй, улс төр эдийн засгийн ухаан судалдаг; бүлгийг зохион байгуулахад тооны нөлөөг хүн ам зүйн судалдаг г.м)⁴⁷ *Товчхондоо, Зиммелийн социологи нь тусгаар нийгмийн ухаануудын судалдаг үзэгдлийг өөрийн судалгааны объект болгодог юм.*

⁴³ “Ойлголтын тухай тодорхой ойлголттой болохын тулд дараах асуултуудыг шүүмжлэлтэй авч үзэх хэрэгтэй гэж Штаммлер бичжээ. Гол ойлголтоо хадгалан ямар бүрэлдэхүүн хэсгүүдийг оюун ухаандаа авч хаях, мөн ямар хэсгийг устгаснаар энэ ойлголт бүрмөсөн алга болох вэ? Эдгээр сүүлийн хэсгүүд нь ойлголтын хэлбэрийг тодорхойлдог бол эхнийх нь түүний материд хамааралтай байдаг.” Өөрөөр хэлбэл, “эхний хэсгүүд нь гол, хоёрдох нь дагалдах тодорхойлолт юм.” Эрх зүйн ерөнхий ойлголт нь эрх зүйн шийдвэрүүдийн олон янз хэсгүүдийн хэлбэр болох ба эрх зүйн шийдвэрүүд нь эрх зүйн ойлголтынхоо матери болдог.”

Штаммлер. Аж ахуй ба эрх зүй. I боть, СПб, 1907. 122. Хэлбэр нь ойлголтыг нөхцөлдүүлж байдаг бол агуулга ба матери нь ил харагдах, тусгаар шинж юм гэдэг нь ойлгомжтой. Энэ санаа нь түүний дараах номонд тусгалаа олсон. *Theorie der Rechtswissenschaft.* Halle. 1911. 7.

⁴⁴ Simmel. *Sociologie.* 3 бүлэг. *Über und Unterordnung.* 141.

⁴⁵ Die quantitative Bestimmtheit der Gruppe хар.

⁴⁶ Дюги. Үндсэн хуулийн эрх зүй. 1908. 24; С.Котляревский. Эрх мэдэл ба эрх зүй. 1915; Павлиенко. Тусгаар тогтнол. 1903; П. Покровский. Төрийн эрх мэдлийн тухай. 1914. XXI-XXII дугаар; Б.Кистяковский. төрийн эрх мэдлийн мөн чанар. 1913. III дугаар; Коркунов, Петражицкий, Тарановский нарын эрх зүйн ерөнхий онолын курс; Эстем, Н.И.Лазаревский нарын төрийн эрх зүйн талаарх курс.

⁴⁷ Simmel. *Sociologie.* 1908. 581-598, 403-453, 47-133.

Тиймээс мэдлэгийн бусад салбарын оролдоогүй “өөрийн талбар” дээр социологи ажиллах ёстой гэсэн түүний үзэл батлагдаагүй юм. Тэрбээр дээрх санаагаар социологийн бие даасан байдлыг үндэслэхийг оролдсон боловч нотолж чадаагүй гэсэн дүгнэлт хийж болно.

Ийнхүү Зиммелийн үзэл санааны тухай яригдсан бүхий л зүйлээс дараах дүгнэлтийг хийж байна.

1) Хэрэв бусад нийгмийн ухаануудын судалдаггүй харилцааны хэлбэрийг социологид зориулан гаргаж ирсэн бол “удирдах” шинжлэх ухааныг үгүйсгэх аргагүй нэмэлт нэгэн салбар ухааныг бүтээсэн гэж үзэх юм. 2) “Хэлбэр” ба “матери”-ийг сөргүүлэн тавьсан Зиммелийн үзэл санаа алдаатай, мөн нэгэн ижил “нийгмийн матери” нь харилцааны олон янз хэлбэрүүдээр илэрч болно хэмээх үзэл буруу, түүнчлэн “харилцааны хэлбэр” хэмээн нэрлэгдэх үзэгдлүүдийг бусад нийгмийн ухаанууд судалдаггүй гэсэн үзэл буруу, эцэст нь “харилцааны хэлбэрийг” геометрийн орон зайн дүрсүүдтэй адилтгах нь ямар ч үндэслэлгүй юм. 3) “Матери ба хэлбэр”-ээр оролдох Зиммелийн оролдлого нь эдгээр ухагдахууныг голлох суурь болон дагалдах ойлголт, үзэгдэл гэж үзсэн тохиолдолд утга агуулгатай болно. Энэ тохиолдолд Зиммелийн үзэл баримтлал нь дээр дурьдсан социологи ба тусгаар нийгмийн ухаануудын хоорондын харилцааны талаарх гуравдах үзэлд хамаарна.

Зохих өөрчлөлттэйгээр Зиммелийн тухай яригдсан бүхий л зүйл хоёрдахь үзлийг баримталдаг бусад сэтгэгчдэд ч мөн адил хамаарна.

Гуравдах асуудлыг авч үзье. *Социологи нь хүмүүсийн хоорондын харилцааны хамгийн ерөнхий шинжүүдийг судалдаг ба түүний зарим төрөл, хэлбэрүүдийг тусгаар нийгмийн ухаанууд судалдаг* хэмээн гуравдах үзэл томъёологддог.

Энэхүү хариулгаас хэд хэдэн асуулт гарч ирж байна. Ийм шинжлэх ухаан хэрэгтэй юу? Энэ нь бүхий л нийгмийн ухаануудын энгийн шошго болох юм биш биз? Социологи нь мөн чанартаа зөвхөн өнгөц, хуумгай зүйл болох вий? Ийм үзэл санаанууд яригдаж байсан, яригдсаар л байна. Үүнд анхаарлаа хандуулья. Шинжлэх ухаанууд ялгарах нь “удирдах” шинжлэх ухаан байхыг үгүйсгэхгүй харин ч оршихыг шаардаж буйг би дээр нэг бус удаа хэлж байсан.

1) Энэхүү үндэслэл нь юуны өмнө хэд хэдэн төрөлд хуваагдаж буй үзэгдлүүд байгаа тохиолдолд эдгээр үзэгдлүүдийн нийтлэг шинжүүдийг судалдаг шинжлэх ухаан байх ёстой гэдэг дээр суурилдаг. “Хэрэв N төрлийн ижил юмс үзэгдэл оршин байвал бол $N+1$ гэсэн шинжлэх ухаан ялангуяа онолууд байх ёстой, жишээ нь хоёр төрөл оршиж байвал $2+1=3$ гэсэн шинжлэх ухаан шаардлагатай болно, хэрэв 3 төрөл байвал 4 шинжлэх ухаан хэрэгтэй болно г.м.”⁴⁸ хэмээх Петражицкийн дүрэм энд үйлчилж болох юм. Энэхүү шаардлага нь онолын зохист зарчмаас үүдэлтэй юм. Хүн ба амьтан нь амьд биетийн ерөнхий аймагт багтах хоёр төрөл болох бөгөөд өөр өөрийн өвөрмөц шинж чанартай байхаас гадна нийтлэг шинжүүдийг агуулдаг. Тиймээс ургамал судлал болон амьтан судлалын зэрэгцээ эдгээрийн нийтлэг, суурь шинжүүдийг судлах зорилго бүхий ерөнхий биологи хэмээх гуравдах шинжлэх ухаан оршин байдаг.

Энэ нь мөн л социологид хамааралтай. Нийгмийн амьдралын юмс үзэгдлийг гүнзгий, тодорхой судлахын тулд шинжлэх ухааны нарийсал хэрэгтэй. Тусгаар шинжлэх ухаан бүр хүмүүсийн хоорондын харилцааны тодорхой төрлүүдийг судалдаг /дээрээс хар/. Гэвч эдгээр бүх төрлүүд нь хүмүүсийн хоорондын харилцааны тодорхой тохиолдлууд учраас ерөнхий суурь шинжүүдийг агуулдаг. Эдгээр суурь шинжүүдийг судлах “удирдах” шинжлэх ухаан байхыг шаардаж байна. Ийм шинжлэх ухаан нь социологи юм. Нийгмийн үзэгдлийн N төрлийг судалдаг тусгаар шинжлэх ухаануудад $N+1$ хэмээх социологи нэгдэж орох ёстой.

2) Ийм “удирдах” шинжлэх ухааны мөн чанар нь хүчээ хэмнэх зарчмыг шаардаж байдаг. Шинжлэх ухаан бүр зөвхөн өөрийн судлах үзэгдлийн хүрээний хууль харилцааг авч үзэхээс гадна тухайн төрлийн бусад үзэгдэлд хамааралтайг судлах нь чухал. Хэрэв эдгээр хууль ба харилцааг боломжит бүх үзэгдэлд ашиглахаар тодорхойлж чадвал зөв хийгээд шинжлэх ухаанч арвилан хэмнэлт болох юм. “Арван лот жинтэй навчин тамхины жин нь масстайгаа пропорциональ хамааралтай ба зайн квадраттай урвуу пропорциональ” хэмээх нөхцөлийн үнэ цэнэ тэгтэй тэнцүү ба энэ нь ч зөв юм. “Бүх биет массдаа шууд пропорциональ хамааралтай” гэсэн дүрэм нь үлэмж өөр байдлаар ойлгогдоно. Ньютоны хууль юуны өмнө хүчээ хэмнэх үүднээс агуу нээлт байсан.⁴⁹

⁴⁸ Петражицкий. Эрх зүйн онолын удиртгал. 80. “Профессор Петражицкий хэлэхдээ үнэн хэрэгтээ хэрэв a төрөл (жишээ нь эрх зүйн үзэгдэл) болон b төрөл (жишээ нь ёс суртахууны үзэгдэл) нь адил үзэгдлийн төрлүүд юм бол тэдгээр нь өөрийн өвөрмөц шинжтэй байхаас гадна ерөнхий шинжүүдийг агуулдаг ба аль аль төрлийн объектыг танин мэдэхийн тулд ерөнхий суурь шинжүүдийг мэдэх хэрэгтэй. Гэхдээ зөвхөн a онол (жишээ нь эрх зүй) ба b (жишээ нь ёс суртахуун) хэмээх 2 салбар ухаан байх нь зөв онол бүхий мэдлэгтэй байж чадахгүй, суурь шинжийн тухай мэдлэггүй бол гажсан онолтой байна. Иймд a төрөл болон b төрлийн өвөрмөц шинжүүдийг судалдаг салбар ухаанаас гадна суурь шинж чанаруудыг судалдаг өөр нэгэн ерөнхий ухаан хэрэгтэй юм.” Мөн тэнд. 80-81.

⁴⁹ “Энэхүү хуулийн нээлт нь таталцлын онолд эргэлт хийсэн гэж Чупров зөв тэмдэглэжээ. Яагаад? Ньютоноос өмнө нар нь бүхэллэг болохынхоо хувьд гаригуудыг татдаг, мөн зайны

Энэ нь олон тусгаар тохиолдлуудыг нэг нийтлэг үзэгдэлд нэгтгэсэн. Энэ нь тусгаар тохиолдлуудад ажиглагдаж байсан таталцлын харилцааг материйн суурь шинж болгосон юм. Үүнд түүний асар том ач холбогдол нь оршиж байна. Хүч хэмнэх үзлийн үүднээс тусгаар тохиолдлуудыг нийтлэг баримт болгож эсвэл харагдаж буй үзэгдэл, шинж чанарыг суурь шинж болгож чадвал энэ нь бодит байдалд нийцэж буй бол шинжлэх ухааны хожил болох юм. Энэхүү зарчмын дагуу харилцааны суурь шинжүүдийг судлах зорилго бүхий социологи орших боломжтойгоос гадна арга зүйн хувьд орших нэн шаардлагатай байна. Хүч хэмнэх үзлийн үүднээс ийм шинжүүдийн тухай шинжлэх ухаан нь том ололт болно.

3) Энэ утгаараа социологийн оршин тогтнохыг тусгаар шинжлэх ухаануудын сонирхол шаардаж байна. Социологи нь индуктив ухаан болохынхоо хувьд нийгмийн харилцааны жижиг баримтуудыг шинжилдэг тусгаар ухаануудтай нягт холбоотой байж түүгээрээ дамжуулан нэгтгэн дүгнэх баримт мэдээллээ авдаг нь эргэлзээгүй. Гиймээс тусгаар ухаанууд нь социологийн тусгай салбар ухаан байж болох юм. Иймд социологийн дэвшил нь тусгаар ухаануудын дэвшлээс хамаарч байдаг.

Хэрэв энэхүү байдал үнэн бол тусгаар ухаануудын дэвшил нь социологийн дэвшлээс хамаарч байдаг гэсэн эсрэг нөхцөл байдал мөн үнэн юм. “Социологи нь тусгаар ухаануудын дэвшилд хэрэгтэй байдгийн нэгэн адил тусгаар ухаанууд нь социологийн өөрийнх нь дэвшилд мөн хэрэгтэй”⁵⁰ хэмээн Duprat зөв хэлжээ. Тусгаар ухаануудын судалдаг харилцааны янз бүрийн үзэгдлүүд тухайлбал, эдийн засгийн, шашны, эрх зүйн, гоо зүйн үзэгдлүүд нь бодит амьдрал дээр тусгаар бус харин нэг нэгэндээ нөлөөлж харилцан холбоотой оршиж байдаг. “Ажилчдын цалин хөлс эрэлт хэрэгцээний харилцаанаас гадна тодорхой ёс суртахууны үзлээс хамаарч байдаг. Энэ нь хүн өөртөө шаардлагатай байгаа сайн сайхан байдлын доод хэмжээний тухай бидний төсөөллөөс хамааран буурч, ихсэж байдаг өөрөөр хэлбэл эцсийн эцэст бие хүний тухай бидний төсөөллөөс хамаардаг. (Үзэл санаа ба эдийн засгийн баримтуудын холбоо хамаарал). Улс төрийн тогтолцооны хэлбэр нь хүн амын тоо болон нягтралаас хамаардаг.”⁵¹ Хөдөлмөрийн хуваарь нь эв нэгдэлтэй тодорхой хэмжээгээр холбоотой.⁵² Нийгмийн эдийн засгийн зохион байгуулалт нь ихэнхдээ шашны итгэл үнэмшлээс хамаарч байдаг.⁵³ Газарзүйн нөхцөл нь үйлдвэрлэлийн зохион байгуулалт, гэр бүлийн хэв маяг, ард түмний зан заншилд тодорхой байдлаар нөлөөлдөг.⁵⁴ Товчхондоо, бодит байдал дээр хүмүүсийн харилцааны бүхий л үзэгдэл хоорондоо холбоотой юм.

Гийм учраас хэрэв эдийн засагч эдийн засгийн үзэгдлүүдээр хязгаарлаж эдийн засгийн бус үзэгдлүүдийг үл анзаарч түүний нөлөөллийг хайхрахгүй өнгөрвөл эдийн засгийн үзэгдлийн бодит харилцааг томъёолох хуулийн оронд эдийн засгийн бодит үйл явцыг төгс тайлбарлаж чадахгүй хийсвэр хуулийг санал болгоно. Иймээс тэрбээр хүссэн ч хүсээгүй ч зөвхөн эдийн засагч байхаас гадна нийгмийн амьдралын үндсэн харилцаануудыг зохицуулдаг социологич болдог. Нөгөө л *mutatis mutandis*-ыг нь бусад шинжлэх ухаанд ч ашиглаж болно. Гямар ч мэргэжилтэн нийгмийн юмс үзэгдлийн янз бүрийн бүлэг төрлүүдийн хоорондын харилцааг тогтоох зохицуулах ажлыг хийхээс өөр аргагүйд хүрдэг. Энд тэрбээр хүссэн ч хүсээгүй ч мэргэжилтэн шиг биш харин социологич шиг ажиллах болдог.

Нийгмийн ахуйн тодорхой шинжийг авч үзэх нь нийгмийн үзэгдлүүдээс олон талт тухайлбал шашны үзэгдлүүдэд нийгмийн үзэгдлийн нийтлэг ойлголтууд хийгээд түүний үндсэн ангилал, ижил болон ялгаатай шинжүүд агуулагддаг. Ийм урьдчилсан нөхцөл болон эдгээр зорилтуудыг зөв шийдвэрлэхгүйгээр тухайлбал эрх зүй, шашин, аж ахуй г.м нийгмийн үзэгдлийн судалж буй төрлийг зөв тодорхойлж чадахгүй, мөн үзэгдлүүдийн хоорондын харилцааг зөв тодорхойлж чадахгүй, түүнчлэн эрх зүй, эдийн засаг, шашны болон бусад салбар ухааны үндсэн зүй тогтлыг зөв танин мэдэж чадахгүй.

квадраттай урвуу хамааралтай хуулийн тухай санаа орж ирж байсан. Ньютон том хэмжээний биетүүдийн хооронд үйлчилдэг хүчийг авч үзэхээс бичил биетүүдийн таталцлын хүчийг судлах шилжилт хийсэн. Энэхүү шилжилт нь оюун ухааны хүчийг хэмнэхтэй холбоотой байсан учраас асуудлын түүхэнд зохих байр сууриа эзэлсэн. Хэрэв энэ салбарт тогтоогдсон баримт болгоныг тусад нь санаж байвал (жишээ нь, 10 лот жин бүхий навчин тамхи, зэс шоо, бөмбөлөг, 2 чулуу г.м таталцлын хуулийн дагуу таталцдаг- П.С) мэдлэг нэмэгдэхийн хэрээр асуудлын хүнд байдал хүний оюун ухааны хязгаарлагдмал чадварын хүрээнээс гарч одно.” Ньютоны нээлтийн тусламжтайгаар бид хүнд байдлаас гарч, олон янз тусгаар баримтууд нь тэр даруй амархан харагдахуйц болж ирсэн. Ажиглалтын бүх баялаг нөөц нь товчхон томъёонд багтаж байна.” А.А.Чупров. Статистикийн онолын тухай өгүүлэх нь. 1909. 9-11.

⁵⁰Duprat. *Science sociale et democratique*. Paris. 19 00. 71.

⁵¹ Coste-г жишээ болгон хар. *Les principes d' une sociologie objective*. 1899; Coste. *L'experience des peuples*. 1900; Simmel. *Sociologie*.

⁵²Дюркхейм. Нийгмийн хөдөлмөрийн хуваарь. 1900; Bougle. *Revue generale des theorie recentes sur la division du travail*. L' annee sociologie. 6 боть. 73-122.

⁵³ Bougle. *Le regime des castes*. 1908.

⁵⁴ Demolins-г жишээ болгон хар. *Comment la route cree le type social*. 1,2 боть.

Тиймээс мэргэжилтэн бүр үргэлж социологич болдог бөгөөд тэгэхээс ч өөр аргагүй. Хэрэв социологийг нийгмийн амьдралын бүхий л талыг хамруулж чадахгүй гэж зэмлэвэл энэхүү зэмлэлийг мэргэжилтэн болгонд хэлж болох боловч тэрээр ил болон далд байдлаар социологич байдаг. “Мэргэжилтэн” нь эдгээр ерөнхий асуултуудыг үе үе шийдвэрлэх болдог бол социологи нь эдгээр асуудлуудыг судалдаг шинжлэх ухаан болохынхоо хувьд төлөвлөгөөтэй, байнга шийдвэрлэдгээрээ хоорондоо ялгаатай. Нэг дэх тохиолдолд яаралтай шийдвэрлэх гэж байгаад илүү их алдаа гаргадаг бол хоёр дахь тохиолдолд алдаа бага гардаг аж.

Өнөөг хүртэл өөрийн судалгааны объектыг хайж буй олон тусгаар шинжлэх ухааны “амжилтгүй байдал” үүгээр тайлбарлагдаж байгаа юм биш үү? Мэдээж, социологи нь тусгаар шинжлэх ухааны мэдээлэлгүйгээр эдгээр асуудлуудыг шууд шийдвэрлэхгүй. Хэрэв түүний ажлын амжилт тусгаар шинжлэх ухааны хөгжил дэвшилээс хамаарч байвал дээр хэлсэнчлэн мөн тусгаар шинжлэх ухааны хөгжил дэвшил социологийн төгөлдөршлөөс хамаардаг. Үүнийг социологийн түүх болон бусад тусгаар шинжлэх ухааны түүхээс харж болно. Тусгаар шинжлэх ухааны хөгжил дэвшил нь социологийг хөгжүүлж мөн эргээд нөгөөдөө нөлөөлдөг, социологийг үндэслэх, хөгжих эцсийн дүндээ бараг бүхий л тусгаар ухаануудад жинхэнэ хувьсгал гарахад хүргэсэн. Сүүлийн арваад жилд тусгаар ухаанууд “социологижих” хандлагатай болсон нь хөгжлийн маргашгүй баримт болж байгаа юм. Эрх зүй, аж ахуй, шашин, гоо зүй, сэтгэл зүй, хэл зүй, ёс зүй, зан заншил, хүн амын шилжилт хөдөлгөөний талаар шинжлэх ухаанууд сүүлийн арваад жилд бүгд их бага хэмжээгээр “социологижиж”, социологийн ерөнхий зарчим, ойлголтууд нэвтрэн орж, улам бүр дүр төрх нь сайжирч, товчхондоо социологийн нөлөөнөөс зайлсхийж чадаагүй юм. Тусгаар ухаанууд “социологижих” нь цаг үеийн бэлгэ тэмдэг. Энэ баримт нь социологи болон тусгаар ухаануудын нягт уялдаа холбоо, харилцан нөхцөлдөх, харилцан хөгжих сонирхолтойг илэрхийлж байна.

Тусгаар ухаанууд нь социологи хэмээх “удирдах” шинжлэх ухаан оршин байхыг шаардаж байгаа нь зөв юм. Тиймээс хэрэв өнөөгийн социологид Дюркхаймийн сургаалийн нөлөөн доор “тусгай” социологийг боловсруулах хандлага харагдаж байгаа бол энэхүү хандлага нь үзэгдлийг философи онцлогтой (Вормс), аргазүйн онцлогтой (Дюркхаймийн сургааль) болон “субстанциональ” онцлогтой (органик реалист сургааль) удирдах буюу ерөнхий социологийг хөгжүүлэхийг шаардаж байгааг Orgaz зөв хэлжээ.⁵⁵

Социологийн аргазүйн үнэ цэнэд анхаарлаа хандуулж байсан Маурас маш зөв юм. “Социологи нь нийгмийн амьдралын зарим тусгай салбарыг үл харгалзан удирдах ерөнхий шинжийг агуулдаг. Өнөөдөр социологи нь бүхий л нийгмийн ухаануудад оршиж байдаг аргазүйн асуудлыг судалгааны объект болгодог ба нийгмийн ухаануудын мэдээллийг цэглэхэд түүний үүрэг оршино. Хожимдоо социологи нь нийгмийн ухаануудын хүрээнээс хальж шинэ асуудлыг дэвшүүлснээр физик шиг нийгмийн үндсэн баримтуудын субстанциональ бодит байдлын тухай мэдлэгийг ерөнхийлэн дүгнэх боломжийг олгодог.”⁵⁶

4) Социологийн бусад тусгаар ухаануудад хандах хандлага нь ерөнхий биологи нь анатомид, физиологи, морфологи, систематик болон бусад биологийн салбар ухаануудад хандах хандлагатай адил юм.⁵⁷ Мөн ерөнхий физик нь акустик, электроник, гэрлийн тухай ухаанд, хими нь органик болон органик бус химид хандах хандлагатай адил юм. Тиймээс социологи хэмээх ерөнхий ухаан байхгүй эсвэл байж болохгүй зөвхөн тусгаар ухаанууд л оршино гэж үзвэл тэрбээр физик хэмээх ерөнхий ухаан, ерөнхий биологи, ерөнхий хими байхгүй гэдгийг батлах хэрэгтэй болно.⁵⁸

Гэвч ийм яриа гарахаа больсон байна. Социологи нь оршин байх эрхийн тухай маргалдах байдлаасаа холдсон байна. Одоо социологийн оршин байх нь баримт болон түүний эрх гэдэг нь эргэлзээгүй.

Социологиос бусад тусгаар нийгмийн ухаануудад хандах хандлага ийм байна. Миний хэлж байсанчлан энэ асуудлаар ихэнх социологичид ийм л байр суурьтай байгаа аж.⁵⁹

⁵⁵ R.Orgas. sociologie generale et sociologie speciale. Revue inter. de soc. 1914. №3.

⁵⁶Maupas. Caracteres et critique de la sociologie. 209.

⁵⁷ “Ерөнхий биологи нь бүх бүлгийн бүх амьд биетүүдийн хуулийг судалдаг гэж Ле-Дантек хэлжээ.” Le-Dantec. II у а une biologie generale. Revue philosophique. 1912. 7 сар. 561-562.

⁵⁸ Де-Роберти. Социологийн үндсэн асуудлыг шинээр авч үзэх нь. 262; Ковалевский. Социологи. I боть. 1910. 1-5 бүлэг. Уншигч эндээс социологийн философи, түүх, угсаатны эрх зүй, улс төр эдийн засгийн ухаанаас ялгаатай асуудлыг дэлгэрэнгүй харж болно.

⁵⁹ Мөн Де-Грефийг хар. Precis de sociol. 8; Мюрселли. Sociologie generale. 1898. 33; Уорд. Социологийн тойм. 1901; Гиддингс. Социологийн үндэс. 1898, II бүлэг; Кост. Les principes d' une sociol.objective. 33; Duprat. Science sociale et democratie. 31-77; Small. Amer. Jour.of sociology. Өгүүлэл. 1912. 9-р сар; Ellwood. Sociology in its psychol. Aspects. 1912; Richard. La sociologie generale et les lois sociologiques. Paris; Палант. Социологийн тойм. 1910. II бүлэг; Кареев. Социологийн судалгааны удиртгал. 1907; Хвостов. Социологи. 1917, 1-3.

Үүгээр бид социологийн тухай урьдчилсан тодорхойлолтыг дуусгая. Би өмнө тавьж байсан гурван үндсэн асуултандаа товч хариулсан. 1) социологи ямар үзэгдлийг судалдаг вэ? 2) яагаад эдгээр үзэгдлүүдийг судлахын тулд тусгай ухаан шаардагдаж байна вэ? 3) социологи болон бусад шинжлэх ухаануудын тухайлбал нийгмийн, физик химийн, биологийн, сэтгэл зүйн ухаануудын харилцаа холбоо ямар байдаг вэ? г.м асуултууд юм.

Дараагийн бүлгүүдэд социологийн дүр төрхийн талаар илүү тодорхой, илүү нарийвчлан авч үзнэ.